

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Мянгар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9-36

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	10
2.Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	10-33
3.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	33-34
4.Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	34
5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	34-36
6.Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	хойшлуулав

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын
09-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, С.Одонтуяа;
Чөлөөтэй: Б.Баярсайхан, Ц.Туваан.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулав./12:23/

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, хуулийн зөвлөх Г.Оюунболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн А.Уранчимэг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Монгол Улсын Их сургуулийн Нийгэм, социологийн тэнхимийн багш, доктор А.Батхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир, С.Чинзориг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын Их сургуулийн Нийгэм, социологийн тэнхимийн багш, доктор А.Батхишиг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Бейсен, Д.Батлут, Ц.Сандаг-Очир, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа нарын /цаашид “Ажлын хэсэг” гэх/ гаргасан, 1.Төслийн 36 дугаар зүйлийн 36.6, 36.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36.6 дахь хэсэг болгох:

“36.6.Суманд гурван мянга, хороонд таван мянга хүртэлх хүн амд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нэг байхаар тооцож ажиллуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн дэд бүлэг, зүйл хэсэг, заалтын “кейс менежмент” гэснийг “эрсдэлт нөхцөлийн зохицуулалт /кейс менежмент/” гэж, “кейс” гэснийг “тохиолдол /кейс/” гэж тохиолдол бүрд тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

П.Анужин: Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалгах шаардлагатай гэж гишүүдийн гуравны хоёр нь үзсэн учир тухайн асуудлаар дахин санал хураалт явуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

П.Анужин: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 36 дугаар зүйлийн 36.2.4 дэх заалтын “тохиолдлын зохицуулалт” гэснийг, мөн зүйлийн 36.2.5 дахь заалтын “тохиолдол” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

П.Анужин: Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалгах шаардлагатай гэж гишүүдийн гуравны хоёр нь үзсэн учир тухайн асуудлаар дахин санал хураалт явуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 13
53.8 хувь буюу гуравны хоёроор санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

П.Анужин: 2.Төслийн 25 дугаар зүйлийн 4 дэх тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүр төрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Монгол Улсын Их сургуулийн Нийгэм, социологийн тэнхимийн багш, доктор А.Батхишиг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, хуулийн зөвлөх Г.Оюунболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн А.Уранчимэг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Монгол Улсын Их сургуулийн Нийгэм, социологийн тэнхимийн багш, доктор А.Батхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, хуулийн зөвлөх Г.Оюунболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн А.Уранчимэг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Монгол Улсын Их сургуулийн Нийгэм, социологийн тэнхимийн багш, доктор А.Батхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, хуулийн зөвлөх Г.Оюунболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн А.Уранчимэг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Монгол Улсын Их сургуулийн Нийгэм, социологийн тэнхимийн багш, доктор А.Батхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 46 минут үргэлжилж, 17 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 76.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 12 цаг 20 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хорооныхоо гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 58.8 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

Батлут гишүүн ирсэн байна. Бейсен гишүүн ирсэн байна. Булгантуяа гишүүн ирсэн байна, Жаргалмаа гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Сарангэрэл, Саранчимэг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Чинбүрэн гишүүн ирсэн байна, Чинзориг гишүүн ирсэн байна, Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Байнгын хорооны 1 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батална.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн анхны хэлэлцүүлгийг мөн хийнэ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл мөн Хүүхэд хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Дараа нь Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын гишүүдээс 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу? Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн санал хэлнэ.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Хэлэлцэх асуудал дотор бас энэ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдтэй холбоотой хуулийн төслийг бид өчигдөр ажлын хэсэг бас хуралдсан. Ингээд хуралдаанаар бол анхны хэлэлцүүлэг хийх хэмжээнд бэлэн болоогүй байгаа учраас үүнийг бас бас хойшлуулах тэгээд ажлын дэд хэсэгт нь илүү сайн боловсруулж ажиллуулах үүрэг өгсөн. Өчигдөр нэг тийм шийдэлд бид хүрсэн байгаа. Тэгэхээр өнөөдөр хэлэлцэх боломж байхгүй байгаа гэдгийг л дуулгая.

П.Анужин: Тэгэхээр Чинбүрэн гишүүн өнөөдөр хэлэлцэх асуудлыг хойшлуулж өгнө үү гэсэн горимын санал тийм үү.

Хэлэлцэх асуудлын дараалалд байсан Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих тухай хуулийн төсөл хуулийн төслийг ахлан ажиллаж байгаа Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн өнөөдөр бас хэлэлцэхэд бэлтгэл хангалтгүй байгаа гэдэг шалтгаанаар өнөөдөр хэлэлцэхийг хойшлуулж өгнө үү гэсэн горимын саналаар санал хурааж өгөөч ээ гэж байна. Чинбүрэн гишүүний гаргасан саналаар горимын саналаар санал хураалт явуулъя, гишүүд ээ. Өнөөдөр хэлэлцэх асуудлыг хойшлуулъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 81.8 хувиар санал дэмжигдлээ. Чинбүрэн гишүүн ажлын хэсгийг ахалж байгаа. Нийгэмд бас маш их хүлээлттэй, санаачилсан гишүүд маань бас бэлтгэлийг хууль судлах, судалгаа шинжилгээний ажлыг бас хангалттай сайн хийсэн гэсэн ийм мэдээлэлтэй. Байнгын хороо байгаа сайн ажиллаж байгаа. Тэгэхээр бас нэгтгэх нарийн чимхлүүр эцсийн байдалд бэлдэх асуудлууд дээрээ асуудал байгаа гэж ойлголоо. Тэгэхээр энэ асуудлыг бас яаравчлан Байнгын хороогоор хэлэлцүүлэх асуудал дээр Чинбүрэн гишүүн бас идэвх санаачилга гаргаж ажиллаарай гэдгийг бас хэлье. Хугацааны чиглэлийн хувьд хаврын чуулган руу л орчихлоо л доо тийм ээ. Уг нь бид өнөөдөр оруулъя гэж их л дээр доороо ярьсан юм сан.

2024 оны 1 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглаврыг батална.

Цаглаврыг эрхэм гишүүд та бүхэнд тараасан байгаа. Байнгын хорооны цаглавартай холбоотой асуулт асууж үг хэлэх гишүүд байна уу? Тараасан байгаа шилэнгээр, бүх

гишүүдэд. Саналтай гишүүд байхгүй бол Байнгын хорооны. Цаглавартай холбоотой асуулт саналтай гишүүд байхгүй байна.

Байнгын хорооны цаглаврын төслийг баталъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувиар 1 дүгээр сарын цаглавар батлагдлаа.

12.25 цаг

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат таныг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хийхийг урьж байна.

Ажлын хэсгийг хуралдааны танхимд урьж байна. Ажлын хэсгийг танилцуулъя.

Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Азжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого зохицуулалтыг хариуцсан мэргэжилтэн, Амарбаясгалан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баттулга Хуулийн зөвлөх өмгөөлөгч, Оюунболд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, Дуламсүрэн БШУЯ-ны шинжээч, Чинбат Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батсайхан Нийслэлийн Гэр

бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга, Нямдорж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга ирээгүй байна шүү. Томилоттой, чөлөө авсан юм байна. Энхбаатарын Оюун-Эрдэнэ Цахим хөгжил харилцаа холбооны яамны мэргэжилтэн, Уранчимэг Харилцаа холбооны зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн гэсэн, ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Болормаа мөн хүрэлцэн ирсэн байна. Өлзийтунгалаг МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн ахлах багш, Батхишиг МУИС-ийн Нийгэм социологийн тэнхимийн багш доктор. Ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн ахлагч Идэрбат таныг хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хийхийг микрофонд урьж байна.

Ц.Идэрбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 1 сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг 2024 оны 1 сарын 9-ний өдөр хуралдаж Улсын Их Хурлын даргаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу дараах зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэлээ. Үүнд:

Нэгд, Суманд 3 мянга, хороонд 5 мянга хүртэлх хүн амд хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан нэг байхаар тооцож ажиллуулахаар. Кэйс менежмент гэдэг нэр томъёог Хэл зохиолын хүрээлэн, хэлний бодлогын үндэсний зөвлөлд хүсэлт

илгээж албан бичгээр хариу авсны дүнд кэйс менежмент нь нийгмийн олон салбарт 20 гаруй жил хэрэглэж хэвшсэн нэр томъёо тул шинээр оноосон хувилбарыг олон нийт хүлээж авахад цаг хугацаа шаардаж магадгүй гэж үзсэн тул нэр томъёог хэвээр үлдээх. 2-т кэйс менежментийн эрсдэлийн менежментийг эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэж оноолоо.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч цахимаар дарамтлах гэсэн тайлбарыг хуульд нийцүүлж дахин тодорхойлох шаардлага үүссэн тул тайлбарыг өөрчиллөө. Түүнчлэн анхны хэлэлцүүлгээр зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40.2-т заасны дагуу боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

П.Анужин: Хуулийн ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүнд баярлалаа. Идэрбат гишүүний танилцуулгатай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Гишүүд нэрсээ өгөөрэй. Бадарчийн Жаргалмаа гишүүнээр үг хэлэх гишүүдийн нэрсийг тасалж байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ, асуулт асууна.

М.Оюунчимэг: Ажлын хэсэг Идэрбат гишүүнтэй сайн ажилласан гэдэгт итгэлтэй байна. Тэгээд хамгийн гол нь энэ хууль бол одоо нөгөө нийгэмд

хамгийн их хүлээлт үүсгэсэн хүсэн хүлээж байгаа нөгөө УАБЗ-ийн түвшинд хүрээд байгаа энэ хүүхэд хамгааллын асуудлыг өөр түвшинд хүргэхэд хууль эрх зүйн болоод санхүүгийн хувьд эрс шинэчлэл хийх ийм хууль болох учиртай. Өмнө нь чуулганаар хэлэлцээд буцаагдсан зүйл дээрээ нөгөө хүүхэд хамгаалагч хүүхдийн байцаагч хөдөө орон нутагт хүүхдийн тэр орон тооны байх дээр нэлээд асуудлууд хөндөгдсөн. Өмнө нь ч гэсэн ер нь хүүхэд хамгаалагчийн байцаагч буюу хүүхэд хамгааллын ажилтан нь өөрөө орон тоо нь хүрэлцдэггүй ялангуяа хөдөө орон нутагт юм уу, дүүргүүдэд хүн ам ихтэй энэ ажилтнуудын тоо нь өөрөө цөөхөн. Дээрээс нь авч байгаа цалин нь амьжиргааны баталгаажих түвшинд бараг хүрэх үгүйтэй. Тэгээд өөрсдөө автобусаар яваад л ингээд дээрээс нь хөдөө орон нутагт янз бүрийн ажил давхар хийдэг гээд маш олон зөрчилтэй зүйлүүд байсан. Энэ хуулиар үүнийг арилгах нь бидний гол зорилго. Тийм ч учраас бид төсөвт өртгийг 8 тэрбумаас 11 тэрбумаас одоо бүр 14 тэрбум төгрөг болгож ингэж өсгөсөн байгаа.

Тэгэхээр ажлын хэсэг энэ хүүхэд хамгаалах боловсон хүчин хүний нөөц дээр яг тодорхой зааж өгөөд санхүүжилтийн тэдэн хувь нь ийм байна, тэдэн хүүхдийн хүүхдэд нэг ийм хүүхэд хамгаалагч хүүхдийн байцаагч байна гэсэн энэ заалтууд хэн ч харсан тодорхой байхаар ингэж тусгаж тодруулж оруулж өгсөн үү? Яагаад гэвэл энэ дээр бол яг ерөнхийдөө бас нөгөө ерөнхий байна л даа. Тэр заалтуудыг нь бас өчигдөр нэлээд уншлаа. Шинэ зүйл заалтуудыг харж байхад. Дээрээс нь энд нэг ийм зүйл байгаа. Хүүхэд хамгааллын үйлчилгээг шинээр томьёолж, хүүхэд хамгааллын үйлчилгээ шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ гэдэг нь өөрөө гэр бүлд суурилсан гэр бүлээс тусгайлан урьдчилан сэргийлэх гэсэн 3 хэлбэрээр авч үзэхээр болсон гээд. Тэгээд энэ хэлбэрүүд нь өөрөө яг агуулга нь яаж өөр өөр байх

юм. Энд түүн дээр яг ажиллах хүний нөөц ажлын байр энд тийм хэмжээний санхүүжилтүүд тусгайлан тусгана эсвэл тухайн кэйстэй уялдуулж санхүүжилтийн асуудлуудыг шийднэ гэдэг агуулгаар ингэж хуваарилж орж ирж байгаа юм уу? Яагаад гэвэл энэ дээр нөгөө санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, орон нутгийн төсөв, үндэсний болон олон улсын төсөл хөтөлбөр гээд ерөнхий олон эх үүсвэрүүдийг нь заачихсан хэр нь яг энэ кэйсүүд дээр бид санхүүжилтийн хэдэн хувь байна энэ дээр хүний нөөц нь тэд байна гээд энэ заалтууд чухал гэж бид чуулган нэг эхний хэлэлцүүлгийн үеэр үүнийг хэлээд ажлын хэсэгт энэ дээр бас гишүүдийн саналыг тусгахыг чиглэл болгож өгч байсан. Тэгээд энэ дээр бас нэг хариулт авчихъя.

3 дахь зүйл нь энэ бид нар хүүхэд хамгааллын ажилтан гэж яриад байгаа. Дээрээс нь нөгөө хамгаалах байрууд дээр бас асуудал нэлээд байгаад байдаг тийм ээ. Тэгэхээр хамгаалах байр дээр ирэх онуудад жишээлбэл яг хүн ам, нөхцөл байдал, гарч байгаа кэйс энэ тэртэй уялдуулаад энэ хамгаалах байр дээр нэлээд их хөрөнгө оруулалтуудыг тусгах бас зайлшгүй шаардлага байгаа талаар яг энэ нөгөө анхан шатан дээр ажиллаж байгаа хүүхэд хамгааллын ажилтнууд бас ярьж байсан. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас хэрхэн тусгаж тодорхой оруулж өгсөн бэ гэсэн асуултууд байна аа? Баярлалаа.

П.Анужин: Ажлын хэсэг Идэрбат гишүүн хариулъя.

Ц.Идэрбат: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь Хүүхэд хамгааллын хуулийн энэ шинэчилсэн найруулгын нэг гол онцлог ялангуяа хүүхэд хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон орон тоог нэмэгдүүлэх дагаад энэ хүүхэд хамгаалалттай холбоотой зардлын асуудлыг бас маш тодорхой тусгаж өгөх нь зүйтэй юмаа гэсэн ийм чиглэлээр ер нь бас ажилласан байгаа. Хүүхэд хамгааллын тогтолцоог бид

сайжруулахын тулд юуны түрүүнд энэ орон тооны асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй юм байна. Ер нь НҮБ-аас өгсөн зөвлөмжийн дагуу хүүхэд хамгааллын конвенцод заагдсан үйл ажиллагаануудаас 2016 онд батлагдсан хууль дээр 2017 онд үнэлгээ өгөхдөө хүүхэд хамгааллын тогтолцоо нь бас тийм тодорхой биш байна. Зардал нь бас мөн тодорхой биш байна гэсэн ийм чиглэлүүдийг бас ерөнхийдөө өгсөн байдаг юм билээ.

Ер нь манай дотоодын хийсэн судалгаагаар ч гэсэн энэ нь баталгаажсаад ингээд явж байгаа. Тийм учраас энэ хуулийн эхний хэлэлцүүлэг дээр 3 мянга хүртэлх хүн амтай газар нэг сум хороонд нэг хүүхэд гэр бүлийн ажилтан байна гэж ингэж оруулж ирсэн. Их Хурлын чуулган дээр бол энэ асуудал бас нэлээн яригдаад бид ажлын хэсгийн зүгээс гүйцээн боловсруулах чиглэл аваад өнөөдөр ингээд танилцуулж байгаа юм. Үүгээрээ бол ер нь Монгол Улсын 330 сумд ер нь 1, 1 гэх хүүхэд хамгааллын ажилтан байхаар Улаанбаатар дагалдах дүүргүүд дээр бол бас 5 мянга орчим хүнд 5 мянган хүнд нэг байхаар гээд ямар ч салаа утгагүй хоёрдмол утгагүйгээр зааж өгсөн байгаа. Ер нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулахад зардал мөнгөний асуудал нэлээн тодорхой байх шаардлагатай байдаг. Өнөөдөр байгаа ингээд 8 тэрбумаар нэмсэн ч гэсэн та нар юу хийж байгаа юм бэ гэдэг ийм олон эргэлзээнүүд байгаад байдаг. Тэгэхээр бид ер нь анхан шатандаа хүүхэд хамгааллын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай байгаа бүхий л төсвүүдийг орон нутагт нь ер нь хуваарилъя. Аймгийн ИТХ-д өргөн барихдаа төсвөө тухайн шатны аймгийн Засаг дарга өргөн барихдаа хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлуудаа нэг мөр оруулж ирье. Дээрээс нь одоо нэг цэгийн үйлчилгээ хүүхэд хамгааллын байрууд, гэр бүлээс хүчирхийлэх, хамгаалах байруудын зардлыг орон нутаг нь хариуцдаг байя. Тэгэхгүй бол энэ яг хэн

хариуцах нь мэдэгдэхгүй ингээд нэг тодорхой бус явдаг юм. Тийм учраас энийгээ бүр тодорхой заагаад өгье. Сумын түвшинд бол энэ хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулахад яг анхан шатанд одоо тэр хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай гэр бүлийн хүчирхийлэлтэй байнга нүүр тулж байдаг хамтарсан багийн зардлыг сумынхаа төсөв дээр бас тавьж өгье гэдэг ийм тодорхой зүйлүүдийг бас тавьж өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ бол улсын төсөв дээр ямар нэгэн өндөр дүнтэй дарамт гэдэг юм уу ирэхгүй болохоор ийм зүйл байгаа гэж ингэж бас үзэж байгаа.

3 дахь нь ер нь хүүхэд хамгааллын ажлыг үйл ажиллагаа явуулахад энэ саяын миний хэлдэг тэр байр савнаас авхуулаад түүний урсгал зардлаас авхуулаад байр нь байлаа гэхэд тэнд ажиллах ажилтны цалин урамшуулал ч гэсэн хаанаас гарах нь тодорхойгүй байдгаас болоод энэ байр байнгын үйл ажиллагаа явуулах хүндрэлтэй нөхцөл байдлууд ч үүсдэг. Алслагдсан сумдад тохиолдол гарлаа гэхэд тэр хүүхдийг хаана хамгаалах вэ, хаана байрлуулах вэ, тэр байрны урсгал зардал бүх юмнууд бас тодорхой бус байдаг юм. Улсын Их Хурал дээр харамсалтай нь энэ хүүхэд хамгааллын тухай хууль хэлэлцэгдэх үед яг энэ зардалтай холбоотой зүйлүүд бол бас санал хураалтаар унасан. Гэхдээ дагалдах хууль Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах дээр ялангуяа аймаг сумын төсөв дээрээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд шаардлагатай байгаа зардлын төсвийг төсөлдөө өргөн барих ёстой гэсэн ийм зүйл заалтаар дэмжигдээд явж байгаа гэдгийг бас хэлье.

Тэгээд ингэснээрээ энэ орон тооны асуудал нь хэрвээ шийдэгдээд мөн дээрээс нь энэ гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр орсон энэ заалтын дагуу бол энэ хүн хүч боловсон хүчний асуудал ч тэр мөн дээрээс нь юуны хувьд бол зардлын хувьд

нэлээн тодорхой болж өгч байгаа гэж ингэж бас...

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Энэ нөгөө өмнөх Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2015 онд уг нь Их Хурал боловсруулаад тэгээд нөгөө 2016 онд баталсан. Гэхдээ батлахдаа нөгөө санхүүжилтийг нь яг тодорхой тусгаж өгөөгүйгээс болоод энэ хууль өнөөдөр хүртэл хэрэгжиж чадаагүй ингээд эрэмдэг зэмдэг болсон л доо. Тэгээд сая ажлын хэсгийн ахлагч ингэж байна. Энэ хүүхэд хамгааллын тэр 5 мянган 1 хүүхэд хамгааллын ажилтан 5 мянган хүүхэд тэгээд л хүүхэд хамгааллын байр төсөв нь орон нутгийнх нь төсөвт нь суулгахаар ингэж зааж өгч байгаа гэж байна. Тэгэхээр 2024 оны 9 сарын 1-нээс энэ хууль хэрэгжлээ гэхэд одоо лав дүүргийн төсөвт нийслэлийн төсөвт яг энэ сая таны ярьсан хүүхэд хамгаалалттай холбоотой төсөв санхүүжилт туссаагүй. Тэгэхээр бид нар энэ дээр 11 тэрбум байсныг 14 тэрбум төгрөг болгоод ингээд бараг 2 дахин төсвийг нь нэмээд байгаа. Тэгээд энэ мөнгийг одоо энэ 2024 оны энэ хууль хэрэгжихээр нөгөө тус нийслэлийн...

П.Анужин: Ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүн хариулт өгье.

Ц.Идэрбат: Энэ төсөвтэй холбоотой асуудлууд төсвийн жилийнхээ хүрээнд явагдана. Ялангуяа саяын хэлсэн энэ орон тоотой холбоотой тухайн Хүүхэд хамгааллын зардал хүүхэд хамгааллын багийн хамтарсан багийн зардалтай холбоотой асуудлууд бол 2025 оны 01 сарын 01-нээс хэрэгжинэ гэж ингэж бас зааж өгч байгаа юм. Яах вэ, энэ хуулийн хэрэгжих хугацааг олон талаас нь ярьсан. 6 сарын 1 ч гэдэг хувилбарууд гарч ирсэн, төсөвтэй холбоотой асуудлууд ч гарч ирсэн. Тэгэхээр яах вэ энэ хууль хэрэгжилттэй холбоотойгоор төсөв шаардахгүйгээр

хийх зохицуулалтууд нэлээн тусгагдсан учраас ер нь 9 сарын 1 хүртэл энэ бэлтгэлээ хангая. 2025 оны 01 сарын 01-нээс бол энэ төсөвтэй холбоотой зохицуулалтуудаа мөрдөөд явах нь зүйтэй юмаа. Бидний хувьд бол төсвийн төслийг өргөн барихдаа гэсэн ийм томъёоллоор Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн одоо энэ хуулийг дагаж гарч байгаа өөрчлөлтөд тусгачихсан байгаа юм.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе, өдрийн мэнд хүргэе. Энэ нийгмийн ажилтан гэдэг хүн чинь ер нь яг энэ нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт нь яг байдаг юм уу? Яг ямар ажил үүрэг гүйцэтгэх чиг үүрэгтэй хүн байх юм. Тэгээд гэр бүл хүүхдийн асуудал хүнд байгаа юу хүнд байгаа, чухал байгаа юу гэвэл чухал байгаа. Тэгээд энэ асуудал энэ хуулийг чинь явж явж ер нь бас энэ нийгмийн ажилтан дээр бүх юм нь төвлөрөөд ингээд нийгмийн ажилтантай л болчихвол тэгээд энэ асуудлууд шийдэгдчих юм шиг ингээд яваад. Тэгээд 1 хуулиар дагаад мянга гаруй орон тоог шинээр бий болгох гэж байна. Бүх засаг захиргааны нэгжид 1 нийгмийн ажилтан гэдэг хүнийг. Гэтэл энэ нийгмийн ажилтны чинь чиг үүрэг нь тодорхой юм уу? Ямар эрх мэдэл бүхий албан тушаалтан байх юм. Газар дээрээ тодорхой арга хэмжээ аваад хэрэгжүүлээд хариуцлага тооцоод явах ийм чиг үүргийн хүн мөн үү? Энэ гэр бүлийн тухайн нэг асуудалтай гэр бүлд орлоо л доо. Тэнд очоод яах юм энэ хүн, энэ зөрчлийг арилгаж чадах юм уу, урьдчилан сэргийлж чадах юм уу? Зүгээр нэг бүртгэл судалгаа хийгээд явж байдаг хүн байх юм уу? Тэгвэл энэ бид нарын эцсийн үр дүн чинь шийдэгдэж чадах юм уу гэдгээс авхуулаад энэ нийгмийн ажилтан гэдэг хүний хийх ажлын чиг үүрэг тодорхойлолт нь юу юм бэ?

Үнэхээр энэ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хариуцлага тооцох эрх бүхий албан тушаалтан мөн үү? Үүнийг нэг тодруулж өгөөч?

Тэгээд үүн дээрээ тулгуурлаад одоо нөгөө хэлэлцүүлэг дээр 3 мянга хүртэлх гээд ингэсэн чинь одоо 5 мянга болгоод оруулаад ирчихсэн. Ингээд зарчмын ялгаа байхгүй, нийслэлийн 200 гаруй хороотой би нийслэл дээр яриад байгаа юм. Сумдыг яриагүй. Багахангай дүүрэг гэхэд нэг ч нийгмийн ажилтангүй байх нь л дээ. Мянга гаруй 2 мянга хүрэхгүйтэй хүн амтай Улаанбаатар хотын том дүүргүүд болохоор бараг 20 хэдэн мянга, 30 мянган хүн амтай хороод бий. Үгүй ээ, тэгэхээр энэ нийгмийн ажилтан гэдэг хүн чинь мянган хүн амтай хороон дээр ч, 20 мянган хүн амтай хороон дээр ч хийх ажил нь тэгээд яг л нэг хүн л хийж байх юм уу. Тэгэхээр ажлын ачаалал гэдэг юм нь энэ хүнд чинь байх юм уу, даах юм уу, 20 мянга, 30 мянган хүн амтай хороон дээр нэг нийгмийн ажилтан байгаад энэ асуудлаас урьдчилан сэргийлж чадах уу?

Би юу гэж санал хэлээд байгаа вэ гэхээр өнөөдөр энэ нийслэлийн 200 гаруй хороон дээр чинь нийгмийн ажилтан гээд юу хэсгийн ахлагч гэдэг нэг орон тоонууд бий. Сая орчим 800, 900 орчим мянган төгрөгийн цалин авч байгаа улсууд бий. Бараг энэ хуулиараа бараг энэ нийслэлийн хороод дээр байгаа энэ хэсгийн ахлагч нарыг бүгдийг нь бараг нийгмийн ажилтны оронтой чиг үүргээр ажиллуулаад явчихвал ер нь яасан юм бэ гэж бодох гээд байгаа байхгүй юу. Нэг хороон дээр доор хаяж 5, 6, 7, 8 бараг 10 хэдэн хэсгийн ахлагчтай хороо байгаа байхгүй юу. Үүнийг бид нар ерөөсөө олж харахгүй байгаа ерөөсөө олж харахгүй байгаа. Ийм гарц гаргалгаа байна гэдгийг хэлээд байгаа. Тэгээд ийм бүл ажлын алба байж байтал ахиад энэ хороон дээр нэг гэр бүлийн хүүхдийн асуудал хариуцсан нэг орон тоог нэмэх юм байна л даа. Энэ ямар үр дүн авчрах вэ? Үүний

цаана өөрөө нөгөө олон улсын хэмжээнд олон хүн ам, орон тоо, төрийн алба нэмэгдэх гээд байгаа учраас дагасан олон мөнгө төсөв шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэ төсөв мөнгө маань үр дүнтэй байж чадах уу л гэж би харах гээд байгаа юм хамгийн гол нь. Тэрнээс энэ асуудлыг эсэргүүцээд байгаадаа биш. Үр дүнтэй байж чадах уу? гэр бүл хүүхдийн асуудлыг шийдэж чадах уу? 20 мянга, 30 мянган хүн амтай хороон дээр энэ асуудлыг нэг хүн шийдэж чадах уу гэдэг асуудлыг л ярих гээд байгаа юм. Тэгээд үүн дээр нэг хариулж өгөөч.

П.Анужин: Сандаг-Очир гишүүний асуултад хуулийн төслийн санаачлагч Засгийн газар Булгантуяа сайд хариулт өгье.

Х.Булгантуяа: Бид нар анх төслийг оруулж ирж байхдаа хэрэгцээ шаардлагад нь ер нь тулгуурлаж нийгмийн ажилтнуудыг оруулахаар заасан байсан.

Ажлын хэсэг дээр яриад 3 мянга хүн тутамд нэг нийгмийн ажилтантай байя гэсэн. Харамсалтай нь тэр бол Улсын Их Хурлын чуулган дээр унасан хэлэлцүүлгийн явцад. Тэгэхээр уг нь энэ бас арай илүү зохистой харьцаа юмаа. 3 мянган хүн гэдэг чинь нэг ингээд өрх 5 ам бүлтэй гээд бодоод үзэхэд 600 орчим өрх дотор нэг хүн гэдэг бол бас том тоо байхгүй юу. Тэгэхээр энэ бол бас харьцангуй ийм өндөр тоо юм. Нийгмийн нийт хүүхдүүдийн 37, 38 хувь нь нийгмийн халамж хамгаалал шаардлагатай өрхүүдэд байгаа учраас нийгмийн ажилтнуудын тоог бид нар эхэн үедээ ялангуяа энэ хүүхдийн асуудал нэлээн намжтал сайжиртал бас тулж ажиллах нь зүйтэй юм байна гэж бид нар үзсэн. Тэгээд харамсалтай нь энэ бол чуулганы санал хураалтын явцад унасан. Хэрвээ одоо оруулж ирж байгаа санал нь ингээд 5 мянга, 4 мянгаас хороод гэх юм бол 5 мянга, аймаг орон нутгуудад гэхээр мянгаас 3 мянга гэдэг. Нэг ийм байдлаар бид нар оруулж ирж байгаа тийм ээ,

Идэрбат гишүүн тийм. Яах вэ, хорооны хэсгийн ахлагч нар бас байж болно. Тэгэхдээ аймаг орон нутгуудад бол хэсгийн ахлагч байхгүй шүү дээ. Аймаг орон нутгуудад бол байхгүй, зөвхөн дүүргүүдэд л хэсгийн ахлагч нар байгаа.

Тэгэхээр хэсгийн ахлагч нарыг тийм хэсгийн ахлагчийн зорилт нь бас өөр. Хэсгийн ахлагч бол одоо ингээд л зар хүргүүлэх, хог ачуулахаас авхуулаад л ерөөсөө энэ хорооны яг л өдөр тутмын үйл ажиллагааг нь хангахад зориулагдсан хүмүүс шүү дээ. Тэгэх дээр нийгмийн ажилтан гэдэг бол бид нарын хуулийн дагуу нийгмийн ажилтны чиглэлээр тусгайлан сурсан боловсрол ингээд юуны байгууллагуудад ажиллаж байсан, тэгээд бүр нэг нарийн мэргэжлийн хүн юм байна гэж бид нар үзээд байгаа юм. Яагаад гэвэл хүүхдийн асуудалд бол хэн ч хамаагүй зүгээр ороод хүүхдийн эрх ашгийг хангахын төлөө энэ хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлах уу, үгүй юү, зөрчилтэй байна уу, үгүй юү. Эрх нь зөрчигдөж байна уу, үгүй юү гэдэг дээр төрийн өмнөөс нэг бодлын үнэлэлт дүгнэлт өгөх гэж байгаа хүмүүс учраас бид нар бас энэ хүмүүсийг мэргэжлийн хүмүүс байх ёстой гэж үзээд байгаа юм.

Хорооны хэсгийн ахлагч нарын тоог бууруулаад эсвэл нийгмийн ажилтнуудын тоог тэгвэл нэмье гэж бас болох байх, тэгэхдээ хорооны хэсгийн ахлагч нарын асуудлыг бол нийслэл шийддэг, нийслэл дүүрэг өөрснөө шийддэг. Тэгэхээр тэр хүмүүсийн тоог цөөрүүлбэ гэдэг асуудлыг бол бид нар энэ хуулиар хөндөгдөж оруулж ирээгүй.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Харин тэр нийгмийн ажилтнууд маань тэгээд ямар эрх үүрэг чиг үүрэгтэй байх юм бэ? 5 мянгаас дээш хүн амтай хороон дээр байх юм байна. Тэгэхээр 1 хороон дээр дор хаяж мянга гаруй өрхтэй байна гэсэн үг. Тэгээд зүгээр нэг шүдгүй арслан

шиг байх юм уу? Өө танайх нэг тийм эрсдэлтэй л айл шүү гээд ингээд юм явчхаад байна. Хариуцлагын арга хэмжээг газар дээр нь авч чадах юм уу? Асуудлыг газар дээр нь таслан зогсоож чадах юм уу? Зүгээр нэг шат дамжлага болоод бүртгэл судалгааг нь зүгээр нэг цагдаагийн байгууллага руу шүүх рүү, тамгын газар луу илгээдэг дамжуулдаг зүгээр нэг тийм хүн болчих юм уу? Энэ чиг үүргийг нь яг хаана хэн баталдаг юм? Ямар эрх үүрэгтэй юм? Ямар хүн байх юм тэр чинь. Үүн дээр нэг бүр тодруулж өгөөч.

П.Анужин: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дэд сайд 5 номерын микрофонд хариулт өгье. 5 номерын микрофоныг нээгээд өгье. Баярлалаа.

С.Зулхар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Нийгмийн ажил хариуцсан энэ ажилтан бол цэвэр мэргэжлийн ажил. Хүүхэд хамгааллын энэ үйл ажиллагааг цэвэр арга зүйн түвшинд нь удирдан зохион байгуулах ийм чиг үүрэг бүхий ийм ажилтан байгаа юм. Хэсгийн ажилтнуудыг та мэдэж байгаа. Хэсгийн ажилтан бол засаг захиргааны анхан шатын нэгжид захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ийм жишээ нь улсууд байдаг. Тэгэхээр энэнээс ялгаатай гэдгийг нэгдүгээрт хэлье. Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн энэ найруулгын хуульд нийгмийн ажилтны чиг үүргийг тухайлан заасан байгаа гэсэн жишээ нь заалт энд байж байгаа. Энэ эрсдэлт нөхцөл байдлыг илрүүлэх, үнэлэх, үүнтэй холбоотой төлөвлөгөө гаргах, хамтарсан багийг арга зүйн түвшинд нь жишээ нь дэмжиж ажиллах гэх мэтчилэн эндээс 9 тухайлсан зүйл заалт байж байгаа. Тэрнээс гадна...

П.Анужин: 5 номерын микрофонд хариултаа гүйцээгээд өгье.

С.Зулхар: Түүнээс гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд бас энэ нийгмийн ажилтны чиг

үүргийг бас тодорхойлсон 7 заалт байгаа юм. Гэр бүлийн тухай хуулийг бол шинэчлэн боловсруулж байгаа ажлын хэсэг дээр бас энэ дээр Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд нийгмийн ажилтны хүлээх үүргүүдийг бас оруулсан байж байгаа. Тэгэхээр энэ нь бол ямар нэгэн байдлаар тэнд арга зүйн түвшинд бүх ажлыг удирдаад явах ийм түвшний хүн байх юм. Гэхдээ энэ мэргэжлийн ийм мэргэжсэн хүн байх юмаа гэдэг ийм байдлаар хуульд оруулсан гэдгийг хэлье.

П.Анужин: Хариулт хангалтгүй байна. Ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүн асуултад тодорхой хариульа.

Ц.Идэрбат: Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа дээр энэ нийгмийн ажилтнуудыг нэмээд үр дүн гарах юм уу. Наад хүмүүсийн чинь ажил үүрэг чиг үүрэг нь тодорхой юм уу гэж асууж байна. Энэ дээр ер нь бидний гаргасан 2016 оны хууль дээр энэ нийгмийн ажилтны орон тоо дээрээс нь энэ хамтарсан багийн үйл ажиллагааны зардал мөнгөтэй холбоотой юмыг зүгээр бөөрөнхийлөөд хаячихсан учраас өнөөдрийн энэ тохиолдол кэйс гараад кэйс гарсных нь дараа л бид одоо тэгээд л нийгмээрээ шогшироод байгаа юм билээ. Тэгээд энэ хуулийн Засгийн газраас өргөн баригдсан хууль. Гэхдээ ажлын хэсэг гарснаар 10 гаруй удаагийн уулзалтуудыг хийсэн. Энд Улаанбаатар хотын хороодоос ч ирсэн хамтарсан багийнхан ч ирсэн. Бүх л зүйлүүд ирсэн оролцсон. Тэндээс ер нь зүгээр энэ хуулийг бид амь оруульа л гэж байгаа бол нэгдүгээрт санхүү мөнгийг нь тодорхой болгоод өгөх ёстой гэсэн ийм чиглэлээр тэр орон нутаг дахь төсвийн зардлын төслийг өргөн барихдаа гэсэн бүр үг өгүүлбэрээр оруулчихсан. 2 дугаарт өнөөдөр байгаа энэ...

П.Анужин: Идэрбат гишүүн асуултад гүйцээж хариульа.

Ц.Идэрбат: Өнөөдөр байгаа бүтцээрээ бид нар яваад ямар ч үр дүнд

хүрэхгүй ээ, хүрэхгүй гэдэг нь тодорхой болсон юм байна лээ. Өнөөдөр гарч байгаа энэ кэйсийнхээ араас хөөцөлдөөд л нэг амьтан цаг наргүй яваад л тэр кэйсийнхээ ч авч гарч чадахгүй байтал дараа дараагийнх нь гардаг юм байна лээ. Тэр урьдчилан сэргийлэх юм эд нар гэдэг зүйл бол энэ хаана хаанаа огт байхгүй юм байна лээ шүү дээ. Бид зүгээр л нэг нийгмийн ажилтан тавьчихсан тэр л хамаг юм хийж байгаа гэж хараад байгаа боловч тийм учраас ер нь зүгээр энэ хуулийг үнэхээр хүүхдийн төлөө амь оруульа энэ хүүхэд хамгааллын үйл ажиллагааг шинэ шатанд гаргая л гэж байгаа бол бид бас нэг хүн хүчийг нь нэмээд, төсөв санхүүг нь тавиад өгөх нь зүйтэй юм л гэж ингээж үзэж байгаа юм. 3 мянга хүртэл гэдэг дээр бол одоо Монгол Улсын 330 сумын тал нь шахуу л орох юм билээ. Аймгийн төвийн сумд дээр нэг 5, 6 хүн нэмэгдэх юм билээ. Хороод дээр нэмэгдэнэ гэж ингээж тооцож байгаа юм.

Тэгэхээр энэ бол айхтар нэг мянга эд нар бол хүрэхгүй ээ хүрэхгүй. Эд нар юу хийх юм гэхээр энэ хуулиар нэлээдгүй тэр 39 дүгээр зүйл дээр байхаа манайхан тэрийг нь еше дэлгэрэнгүй тайлбарлаад өг л дөө та нар. Нэгэнт заагаад өгчихсөн юмыг тойруулж яриаад байх юм. Тэр 39 дүгээр зүйл дээр байгаа дээрээс нь энэ хуулийн юмнууд байгаа. Үл хайхрах гэдэг зүйлийг олон хуулиуд дээр хэрэглэсэн болов чиг үл хайхрах гэдгийг юу гэж үзэж байгаа талаар ямар ч тодорхойлолт байхгүй байсан юм билээ. Тэгээд энэ хуулиар оруулаад ирж байгаа юм.

Тэгээд тэр үл хайхрах гэдэг энэ процессыг бол энэ нийгмийн ажилтнууд л араас нь үзэж харж урьдчилан сэргийлэх ийм үйл ажиллагаануудыг хийх ёстой. Хэсгийн хороо хэсэг дээр одоо хорооны ажилтнууд байгаа л гэж ингээж тайлбарлаж байгаа. Яг үнэндээ тэр хүмүүс чинь сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байгаа шүү тийм. Тэр хүмүүс хариуцлага тооцоход нэг их

айхтар дагаад төрийн албаны хуулиар хариуцлага тооцох юм бол барагтай л байхгүй. Энэ дээр бол бид нар нийгмийн ажилтан гэж бүр багш, нийгмийн ажилтны ухаанаар суралцсан ийм хүмүүсийг байлгая. Ингэж байж бид нар энэ хүүхэд хамгааллынхаа юм руу гүн рүү орохгүй бол зүгээр нэг тэтгэвэртээ гарсан хүнийг сайн дураараа авч ажиллуулаад ингээд явах бололцоо бол бас хараахан байхгүй байна.

Тэгээд ингээд тоо нь л их өндөр яригдах гээд байгаа болов чиг манай дэд ажлын хэсгийнхэн бол Сангийн яамнаас эд нар бас санал юмнууд авсан байдаг. Тэндээс бол нэг 12, 13 тэрбум төгрөгийн л асуудал яригдаж байгаа юм билээ. Тэгэхээр яах вэ зүгээр энэ хууль нэгэнт ингээд 6, 7 жилийн дараа нэмэлт, өөрчлөлтөөр ингэж орж шинэчилсэн найруулгаар орж ирж байгаагийнх санхүүгийнх нь хувьд тодорхой болчихоосой. Хүн хүчээ нэмээд бас нэг үйл ажиллагаа явуулахгүй бол одоо байгаа процессоор бид нар урьдчилан сэргийлэх гэдэг юм бол байхгүй, гарсан кэйсийн араас явъя ч хүн хүч нь хүрэхгүй нэг иймэрхүү л дүр зурагтай байгаа юм билээ. Тэгээд үүнийг бол бас олон уулзалтуудаас гарсан санал дээр үндэслэж бас хийсэн юм байгаа юм. Бидний хувьд бол бас боловсролын байгууллагууд дээр нийгмийн ажилтныг нэмэх ийм бас саналтай байсан. Гэхдээ боловсролын шинэ хуулиараа боловсролын нийгмийн ажилтнуудыг бол жил болгон нэмэгдүүлээд ингээд явж байгаа юм байна.

Тэгэхээр ер нь бол засаг захиргааныхаа нэгжийн хувиар ч тэр, боловсролын байгууллагынхаа хувьд ч тэр энэ хүүхэд хамгааллын асуудал дээр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх гэдэг ийм юм руугаа л ер нь эртхэн явах нь зүйтэй юм байна л гэсэн ийм бодлогоор энэ нийгмийн ажилтан гэсэн орон тоог бас ингэж оруулж ирээд байгаа юм гэдгийг бас хэлье. Манай ажлын хэсгийнхэн тэр 39 дээр байгаа байх аа

нийгмийн ажилтны эрх үүрэг гээд 36 дээр.

П.Анужин: Тэр 36-г ч яах вэ, гишүүд өөрсдөө хараад хуулиа мэдэж байгаа. Яах вэ энэ Улсын Их Хурал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн энэ зарчмын зөрүүтэй санал дээр гишүүдийн асуугаад байгаа энэ зүйл бол тусгагдаад ороод ирсэн байгаа. Гэхдээ гишүүдийн асуусан асуулт бол хариулт хангалтгүй. Энэ асууж шаардаж байгаа зүйлүүд бол хуульд тусгагдаагүй байна гэдэг ийм л зүйл хариултуудаас харагдаад байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Байнгын хорооны эрхэм гишүүд ажлын хэсгийн гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Би энэ хуулийг дэмжиж байгаа. Өргөн барьснаар нь ч, Идэрбат гишүүн ажлын хэсгийг нь ахлаад, ажлын дэд хэсгийнхэнтэй нэлээн их цаг зав зарцуулаад чухал хуулийг улам сайжруулаад явж байгаад баяртай байгаа. Тэгээд энэ дээр зүгээр нэг 2 юм л бодогдоод байгаа юм. Бид нарт Их Хурлын гишүүд улс төрчид бид нарт нэг том дутагдал байгаа юм. Нөгөө хууль баталчхаад л гарч ирээд л нийгэмд ерөөсөө одоо ингээд л болоо энэ асуудал ингээд шийдэгдчихлээ. Ерөөсөө аймаар чухал хууль одоо үүнийг ингээд л ерөөсөө энэ асуудал ингээд маргааш ингээд л өргөс авчихсан юм шиг л сайхан болчих юм шиг бид нар нэг ойлгуулаад байдаг нэг том дутагдал байгаа юм. Тэгээд энэ хууль дээрээ битгий тэгээсэй л гэж би Их Хурлын гишүүдээсээ ажлын хэсгийнхэн, ажлын дэд хэсгийнхнээс хүсээд байгаа юм. Энэ хүүхэд хамгааллыг сайжруулна шинэ түвшинд гаргана гэдэг бол урт хугацааны олон жилийн нөр их хөдөлмөр болно шүү дээ. Энэ хууль батлагдаад бид нар чухал ажил хийж байна, суурийг нь тавьж байна. Гэхдээ асуудал нэг өдрийн дотор шийдэгдэхгүй ээ тэгээд нийгэмд ингээд нэг буруу хүлээлт л үүсгээд баймааргүй байгаа юм. Түүн дээр бүгдээрээ тал талаасаа анхаармаар байна.

2-т, энэ сумд хороонд хүн амын тооноос шалтгаалаад нийгмийн ажилтан нэмнэ гэдэг заалт дээр зарчим нь зөв л дөө. Хүний тоо нэммээр байна тэгж байж тэр нөгөө үл хайхрах хайхраад байгаа нэрлэжид гэж яриад байгаа хүүхдээ асарч хамгаалахгүй байгаа хүмүүсийг олно, тэр хүүхдүүдэд хайр халамж хүргэнэ гээд ингээд чухал. Гэхдээ энэ дээр нэг л юмыг бид нар бодмоор байгаа юм. Энэ тоо тавих өөрөө ер нь их тийм буруу жишиг байхгүй юу. Үүнийг бид нар ерөөсөө Улсын Их Хурал дээр ч бүх намууд энэ олон жил дараалаад явж байгаа энэ их олон их хурлууд чинь тооноос их зайлсхийдэг байхгүй юу. Одоо хууль батлахлаар л шинжлэх ухаан энэ шинжлэх ухааныг хөгжүүлэх тухай хууль гээд л оруулаад ирэхээрээ ДНБ-ий 3-аас доошгүй хувийг шинжлэх ухаанд зарцуулна гээд л ороод ирдэг. Цагдаагийн хууль оруулаад ирэхээр төсвийн 10-аас доошгүй хувийг цагдаад зарцуулна гээд л. Боловсролын хууль батлахаараа ДНБ-ий төдөөс доошгүй хувийг зарцуулна гээд л эсвэл төдөн хүнд доошгүй төдөн хүн байлгана гээд энэ чинь өөрөө амьдрал дээр ерөөсөө хэрэгждэггүй аягүй хүнд заалтууд байхгүй юу. Тэгээд энэ одоо яах вэ хамгийн сүүлийн хувилбараар ингээд ороод ирчихсэн юм байна. Энэ заалтыг хэрэгжүүлэхэд хүнд дээ. Тэгэхдээ энэ заалтыг хэрэгжүүлэх юм бол Идэрбат гишүүн ээ, ядаж нэг 2026 онд улсын төсөв мөнгөө харж байгаад 2025 онд энэ амжихгүй дээ. 2026 оны 01 сарын 01-нээс хиймээр байгаа юм.

2 дугаарт, би нэг ийм санал хэлэх гэсэн юм. Энэ ерөөсөө аливаа асуудал байна шүү дээ төсөв мөнгө нэмээд л, хүний тоо нэмээд байвал асуудал шийдэгдэнэ гэдэг бидний бодол бас буруу шүү. Мэдээж хэрэгтэй л дээ. Хүнгүй төсөвгүй асуудал шийдэгдэхгүй. Тэгэхдээ ганцхан түүгээр асуудал шийдэх гээд байна гэдэг ойлголт бид нар нийгэмд бас төрүүлчих вий дээ. Ингээд л хүний тоо нэмчихсэн, байцаагч нэмчихсэн, ингээд л асуудал шийдэгдэнэ гээд. Энэ

хандлагаасаа бас жоохон зайлсхиймээр байгаа юм.

3-т нь, энэ кэйс менежмент гэж үгийг эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэж бүр ойлгомжгүй болгочхож байгаа юм. Кэйс менежмент гэдэг чинь хэдийгээр гадаад үг ч гэсэн өргөн барьснаараа кэйс менежмент нь уул нь зөв байгаа байхгүй юу. Одоо энэ манай шүүхийн практикт ч гэсэн кэйс менежмент гэж үг хэрэглэдэг шүү дээ. Нэхэмжлэл өглөө тэрийг авлаа. Асуудал шийдэн шийдэгдтэл тэр чинь кэйс менежментийн шат дараалаар явж байгаа байхгүй юу. Эрсдэлийн менежмент гэдэг чинь риск менежмент шал тусдаа юм. Эрсдэлийн менежмент...

П.Анужин: Мөнх-Оргил гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Эрсдэлийн менежмент гэдэг чинь одоо жишээ нь манай гаалийн хууль дээр байгаа байхгүй юу. Байнга гаалийн татвараа төлдөггүй худлаа мэдүүлэг олгоод өгөөд байдаг эсвэл хүн амын аюулгүй байдал, амь нас, аюулгүй байдалд аюул учруулж байгаа бараа бүтээгдэхүүн энэ илүү эрсдэлтэй юм, энэ этгээд илүү эрсдэлтэй юмаа гэдгээ тооцоод тэд нар дээр илүү шалгалт хийх жишээ нь эсвэл одоо мэргэжлийн хяналт дээр ч юм уу эсвэл танай байцаагч нар очоод энэ айл гайгүй ээ, тэр айл илүү шүү энэ бол эрсдэлийн менежмент байхгүй юу. Тэгээд ингээд 2 өөр юмаа хутгаад бүр хэцүү болгоод ороод ирэх юм.

Тэгэхээр энэ кэйс менежмент гэдэг үг нь зөв байх аа. Тэрүүгээрээ явчихъя. Тэгээд л дасаад л зохицохоос. Тохиолдлын менежмент гэвэл бүр буруу болно. Манай шүүхийн юунд бол энэ хэргийн менежмент гэдэг л юмаар хүчинтэй л яваад байгаа юм. Тэгэхдээ ер нь бол байнга хэрэглэдэг юм нь тогтчихсон хэллэг нь бол кэйс менежмент болчихсон юм шүү дээ.

Шүүхийн тамгын газрын дадлага практикт...

П.Анужин: Тэгье, нэмэлт тайлбар авъя.

Дээрээс нь энэ Мөнх-Оргил гишүүн бас сая олон гишүүд санаа зовоод хэлээд байгаа. Орон тоо тэгээд төсөв нэмэх хүүхдийн асуудлыг шийднэ гэдгээр оруулж ирж байгаа боловч энэ нь хэр бодитой юм бэ гэдэг асуудлыг асуугаад байгаа юм. Тэгээд энэ нь 2025 оноос хэрэгжинэ гээд хууль дээрээ орж ирсэн, хэлэлцүүлгийн шатанд огт хөндөгдөөгүй учраас энэ тал дээр бол одоо эргэж хэлэлцэхэд бол хуулийн дагуу ингээд хаалттай болчхож байгаа гэдгийг бас гишүүд мэдэж байгаа. Энэ дээр бас тодруулга. Булгантуяа сайд. Асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд Содномын Чинзориг гишүүнийг хийгээд өгөөрэй ажлын албаныхан. За Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Мөнх-Оргил гишүүнтэй хэд хэдэн зүйл дээр санал нэг байна. Нэг хууль батлагдаад нэг асуудал шийдэгдэнэ гэж ерөөсөө байхгүй. Энэ хүүхэд хамгааллын тухай хууль бол хүүхэд хамгаалал хүүхэд хамгаалал шаардлагатай хүүхдийг хамгаалах ийм маш их процессын тухай хууль. Хүүхэд спортын тэмцээнд орж байхад, хүүхэд нийгмийн үйл ажиллагаанд орж байхад хүүхэд гэртээ өөрийнх нь эрх ашиг нь зөрчигдөөд байхад хүүхэд сургууль дээр ингээд эрх ашиг нь зөрчигдөөд байгаа тохиолдолд хэн ямар үүрэг хүлээж төр хамгаалах бас үүрэгтэй учраас ямар үүрэг хүлээж түүн дээр төрийн ямар байгууллагууд ямар процессын дагуу үүн дээр бид нар оролцох вэ гэдэг ийм маш их процессын тухай хууль. Гэхдээ Монгол Улс хүүхэд хэзээ 100 хувь хамгаалагдах вэ гэхээр 100 хувь хамгаалагдсан ер нь улс гэж бараг байхгүй байх. Тэгэхдээ энэ ядуурал, ажилгүйдэл, архидалт, нийгмийн амгалан тайван байдал өнөөдөр бий болоогүй байгаа цагт өөрийгөө хамгаалах эрх зүйн болон

санхүүгийн боломжгүй хүүхдүүд хамгийн түрүүнд л хүчирхийлэлд өртөөд л эрх нь зөрчигдөөд байгаа асуудал. Кэйс менежмент гэдэг нэрийн хувьд бид нар бас Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс үүн дээр бас тайлбар авсан. Тэгэхэд яг кэйс менежмент нь гэдгийг ер нь бас бусад олон салбарт хэрэглэдэг. Тийм учраас бараг хориод салбарт хэрэглэгдэж байгаа ийм нэр томъёо учраас кэйс менежмент гэдэг чиглэлээр энэ үгээр нь ер нь явуулах нь зүйтэй юм гэсэн бид нарт бас ийм ер нь чиглэлийг бас өгсөн. 20 гаруй жил кэйс менежмент гэсэн хэлбэрээр хэрэглэж хэвшсэн.

Шинээр оноосон хувилбарыг олон нийт хүлээж авахад цаг хугацаа шаардах ийм нөхцөл байдал бас үүсэж болзошгүй ээ гээд. Дээрээс нь нэмээд энэ яг таны хэлж байгаа энэ шүүхийн шийдвэр гэх мэтчилэн бусад салбаруудад ч гэсэндээ бас яг кэйс менежмент гээд л үүсгэж хэрэглэж явсан тул энэ чигээр нь ер нь явуулах нь зүйтэй юм байна гэж бас үзэж байгаа.

Одоо хороодод яах вэ нийгмийн ажилтан байхгүй биш байна. Тэгэхдээ түрүүний хэлсэнчлэн зарим хороод бол 10 хэдэн мянган хүнтэй 20 гаруй мянган хүнтэй. Тэгээд тэр тусмаа ялангуяа манай захын хороод бол ийм эрсдэл маш их ихтэй. Дээрээс нь нэмээд манай хороодод нэг ерөөсөө бүхий л нийгмийнхээ бүхий л хүн амыг хариуцсан нэг л нийгмийн ажилтантай. Тэгээд бид нар яах вэ үүнтэй холбоотойгоор орон тоо бол нэмэгдэхийн хувьд нэмэгдэх юм байна гээд төсөв өргөн барихаас энэ хуулийн төслийг өргөн барихаас өмнө бас Сангийн яамнаас үүнтэй холбоотойгоор, төсөв нэмэхтэй холбоотойгоор бас саналыг бас авсан.

Одоо нэг ийм л нөхцөл байдал үүсчхээд байна л даа. Дэлхийн зарим улс орнууд цахимжилт энэ тэр нь бүр дээд түвшиндээ хүрчихсэн барьчихсан ийм улсууд бол арай дээр байх. Гэхдээ манай

захын хороодод хөдөө орон нутагт бүх асуудлыг цахимаар зайнаас бид нар хүүхдийн асуудлыг хянана гэдэг бол их хэцүү байгаад байгаа. Тэгээд зөвхөн энэ хүүхдийн асуудлыг харсан бүх хүүхдүүдээ бүртгэлжүүлээд энэ хүүхдийн энэ хамгаалсан нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт байгаа. Тэр хүүхдийн өмнөөс өргөдөл гомдол гаргадаг, кэйсийг нь үүсгэдэг, араас нь хөөцөлддөг, буцаад эцэг эхэд нь эцэг эх байх эрхийг нь сэргээхэд араас нь байнгын гэрээр нь очиж хяналт тавьдаг, дээрээс нь нэмээд тухайн сургуулийнх нь нийгмийн ажилтнуудтай нь холбогддог, багштай нь холбогддог гэх мэтчилэн маш их олон ажлыг хийдэг.

Өмнө нь НҮБ-ын хүүхдийн сангаас манай Хүүхэд хамгааллын тухай хууль дээр хийсэн үнэлэлт дүгнэлт дээр ч гэсэндээ бас яг үүнийг бичсэн байсан. Бүр Чингэлтэй дүүргийн кэйсийг бичсэн байсан. Энэ бол нэг хүний хувьд ийм их олон ажлыг хийгээд үр дүн гаргана гэдэг бол боломжгүй юм. Тэгэхээр энэ 1.2 сая хүүхдийн асуудлыг хэрвээ үүнээс 37, 38 хувь нь нийгмийн халамж хамгаалалд шаардлагатай хүүхдүүд байгаа цагт орон тоог нэмэхгүйгээр, төсөв санхүүг нэмэхгүйгээр энэ асуудлыг шийднэ гэж байхгүй ээ гэж 2016, 2017 онд бид нар дээр гаргаж өгсөн тооцооллоор 11 орчим тэрбум төгрөг энэ хуулийг анх боловсруулахад хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж гаргаж байсан. Мэдээж орон тоо нэмэнгүүт бүх...

П.Анужин: Мөнх-Оргил гишүүний бас санал хэлсэн кэйс менежментийн хувьд ажлын хэсгийн ахлагч Идэрбат ахлагч бас байнгын хороон дээрээ ер нь ярьж эргэж хэлэлцэж шийдье ээ гэсэн ийм байр суурийг илэрхийлсэн. Зарчмын зөрүүтэй саналд ч гэсэн энэ асуудал тусгагдсан байгаа. Сая Булгантуяа сайд хэлж байна. Хэл шинжлэлийн хэлний хүрээлэнгээс 20 гаруй хуульд кэйс менежментээрээ явж байгаа боловч нутагшихад цаг хугацаа хэрэгтэй гэж. Хэл шинжлэлийн хүрээлэнгээс ирүүлсэн

санал нь болохоороо эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэдгээр орчуулаад оруулаад ирсэн болов чиг мэргэжлийн яам бол энэ бол бид нарын илэрхийлэх санаанаас бүр нэлээн бас гажсан ийм байна гэдэг ийм саналыг хэлж байгаа. Тэгэхээр зарчмын зөрүүтэй санал хураалгахад эдгээр саналуудыг авч үзэж хэл хэлэлцэж тухай бүрд нь санал хураалгах бүрэн боломжтой гэдгийг бас хэлье.

Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Хүүхэд хамгааллын тухай хууль яг хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Хүлээгдэж байсан хууль яагаад хэрэгтэй юм бэ гэхлээр Монгол Улсын төрөөс хүүхэд хамгааллын бодлогод шаардлагатай санхүү, төсөв, хүний нөөцийн асуудал шийдэгдэх яг энэ салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд болон бусад ажилтнуудын эрх зүйг хангаж өгөх шаардлага үүссэн үү гэвэл үүссэн. Хүүхэд хамгааллын хууль орж ирэхтэй зэрэгцээд Их Хурлын гишүүд ч гэсэн бас ихээхэн ярьж байна л даа. Өөрөөр хэлэх юм бол гэр бүл нь юу хийх юм, аав ээж нь юу хийх гээд байгаа юм, аав ээж нь хүүхдээ яаж хамгаалах гээд байгаа юм. Гэр бүлийн тухай хуульд энийгээ яаж тусгасан юм гээд.

Сая ч гэсэн нийгмийн ажилтны тухай асуудал яригдаж байна. Нийгмийн ажилтны тухай хууль ч гэсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр боловсруулагдаад өргөн барихад бэлэн болсон байгаа. Үнэхээр бид салбар салбартаа хүүхэд хамгааллын бодлогыг нэг чигт харуулах энэ шаардлага үүссэн үү гэвэл үүссэн. Сая ч гэсэн Булгантуяа сайд хэллээ. 1.2 сая хүүхдийн энэ асуудал дээр хүүхэд хамгааллын бодлого бол дутагдалтай байгааг мэднэ. Хууль эрх зүйн орчны зохицуулалт шаардагдаж байгаа учраас бид хийх гэж байна гэж. Үнэхээр бүгд хүүхдийнхээ төлөө ажиллах ёстой юу гэвэл бүгд хүүхдийнхээ төлөө ажиллах ёстой. Гэхдээ дунд нь

орхигдуулдаг, цалгардуулдаг, хүүхэд хүчирхийлэлд өртдөг хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах тэр боломж нь хангагдаж чадахгүй байх ийм эрсдэлүүд байгаа юу гэвэл байгаа. Тийм ч учраас энэ хууль өнөөдөр Их Хурал дээр хэлэлцэгдээд явж байгаа. Бид хууль анх орж ирэхтэй зэрэгцээд кэйс менежмент гэсэн бүхэл бүтэн бүлэг байх юм.

Монгол Улсын газар нутаг дээр хэрэгжих хууль учраас үүнийг монголчлох хэлнээ буулгах ёстой гэдэг ийм шаардлага тавьсан. Тэр ч үүднээсээ тохиолдлын зохицуулалт гэдгээрээ хуулийн төсөлдөө бас зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор хуулийн төслөө өөрчлөлт хийгээд Их Хурлын эхний хэлэлцүүлгээр бас хэлэлцүүлсэн. Их Хурлын даргаас чиглэл өгсний адил бид нар Монгол хэлний үндэсний зөвлөлөөс бас чиглэл авсан. Хэлний зөвлөлөөс ирсэн тайлбар дээр эрсдэл нөхцөлийн зохицуулалт гээд ороод ирж байгаа юм. Эрсдэлт нөхцөлийн зохицуулалт эрсдэлтэй нөхцөл байх уу зүгээр тохиолдол байх уу гэдэг дээр бид нар авч үзэх ёстой. Яг энэ дээр бас нэгэнт одоо олон нийт бас биднийг харж байгаа учраас энэ салбарт ажилладаг тийм ээ хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа мэргэжилтнүүд маань эрдэмтэн судлаачид маань бас тайлбарыг хэлээч ээ гэж хүсэх байна.

Өөрөөр хэлэх юм бол кэйс менежментээр байх уу, эрсдэлт нөхцөлийн зохицуулалтаар байх уу? Бид нар бас ажлын хэсэг дээрээ санал хураагаад явахаар ер нь монголчилгээ гэдэг дээр санал нэгдсэн. Гэхдээ тохиолдлын зохицуулалтаараа байх уу, эрсдэлт нөхцөлийн зохицуулалтаараа байх уу. Ер нь кэйс менежмент гэдэг бүхэл бүтэн Монгол Улсын газар нутаг дээр хэрэгжих хууль дээр гадаад нэр томьёо бүлгээрээ бүлэг болж орж ирэх нь жоохон өөрөө буруу юм. Тийм учраас монголчилгээ гэдэг санал гаргасан уу гэвэл гаргасан. Яг олон нийт харж байгаа учраас кэйс менежментийг тайлбарлаж

өгөөч? Монгол хэлний зүйл болохоороо эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэж орчуулж орж ирсэн байна тийм ээ. Тэгэхээр энэ дээр нэг тайлбар өгөөд олон нийтдээ бас мэдээлэл өгөөч ээ гэж хүсэх байна.

П.Анужин: Жаргалмаа гишүүн санал хэллээ тиймээ. Өөрийнхөө асуултад бас тайлбар хэрэгтэй гэж үзэж байгаа учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 3 номерын микрофонд хариулт өгье. Батхишиг багш өгөх нь 3 номерын микрофоныг нээж өгье. Асуултад тодорхой хариулаарай.

А.Батхишиг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Мөн ажлын хэсгийн нөхдийн амрыг эрье. Кэйс менежмент гэдэг үгийг сая Мөнх-Оргил гишүүн маш тодорхой хэллээ. Хүүхэд хамгааллын салбарт кэйс менежмент гэдэг үг бол тухайн хүүхдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн ямар нэгэн ямар нэгэн сэжиг таамаг тохиолдолд ч юм уу мэдээлэгдсэн тохиолдолд энэ хүүхэд маань хүчирхийлэлд байгаа эсэхийг илрүүлэх, илэрсэн хэрвээ хүчирхийллийн илэрсэн нь нотлогдох юм бол тухайн хүүхдэд яах вэ, гэхээр шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, эргээд тэр хүүхдийг хэвийн амьдралд нь оруулахад нь туслах, дахин хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх гэсэн ийм шат дараалсан арга хэмжээг авч явдаг юм.

Тэгэхээр энэ хэлний зөвлөлөөс гаргасан эрсдэлт нөхцөлийн менежмент гэдэг бол кэйс менежментийн зөвхөн нэг хэсэг. Өөрөөр хэлэх юм бол кэйс менежментийн гол амин сүнс нь хүүхэд байдаг. Хүүхдийн цаана бол хүүхдийн гэр бүл байдаг. Тэгэхээр кэйс менежер хийж байгаа буюу кэйсийг зохицуулж байгаа удирдан чиглүүлж байгаа нийгмийн ажилтан хүүхэд түүний гэр бүлийн тулгарч байгаа асуудлыг ишидэхэд нь туслах, 2 дугаарт хүүхдэд тохиолдож байгаа эрсдэлийн хүчин зүйлсийг бууруулах буюу багасгах эсвэл үгүй хийх, тэр тухайн хүүхдэд байгаа гэр бүлд

байгаа, өдий хүртэл нь тэр хүүхдийг эрсдэлийн эсрэг, хүчирхийллийн эсрэг авч явж байгаа тэр хамгаалах хүчин зүйл өөрөөр хэлэх юм бол эцэг эх, хамаатан садан, анги хамт олны дэмжлэг, магадгүй ээж, аавынх нь мэдлэг энэ бүх зүйлүүдийг улам бэхжүүлэхэд нь туслах, эргээд дахин хүчирхийлэл гарахаас сэргийлэхэд нь туслах орчны хүчин зүйл нөлөөллийг сайжруулах гэх мэтчилэн өөрөөр хэлэх юм бол кэйс менежментийн дотор хүүхэд, түүний гэр бүл хүүхдэд тулгарч байгаа эрсдэл хүүхдийг эрсдэлээс хамгаалах хүчин зүйл, хүүхдийг аюулгүй байлгах бүхэл бүтэн систем орчин ордог юм. Тийм учраас бид хэд бол манай ажлын хэсгийн ерөнхийдөө Кэйс менежмент гэдэг үгийг хуульдаа бүхэл бүтэн бүлэг болгож оруулсан юм. Баярлалаа.

П.Анужин: Содномын Чинзориг сайд асуулт асууна.

С.Чинзориг: Би яах вэ, Хүүхэд хамгааллын тухай хуулийг зарчмын хувьд дэмжээд байгаа юм. Бид ер нь Их Хурал, Их Хурлын гишүүд, Байнгын хороо ч гэсэн нэг юман дээр л анхаармаар байгаа юм даа. Хууль хийхээр, бид нар хууль хийхээр яг Хүүхэд хамгааллын хууль хийж байгаа яг тэр хүүхдэд бид нар ямар тусламж үйлчилгээ үзүүлэх вэ гэдгээ уг нь эхэлж их сайн ярьж баймаар байгаа юм. Тэгээд бидний нэг практик туршлагатай гээд тэрийгээ ярихаасаа урьдаар л хууль хийхээр эсвэл төрийн захиргааны байгууллагууд өөрсдөдөө баахан эрх авдаг эрх авах гэсэн юм ярьдаг, эсвэл баахан бүтэц орон тоо ярьдаг яг тэр хүүхэдтэй холбоотой тусламж үйлчилгээний юмыг нь хэр бас ярьсан юм бол. Одоо тэрийг нь орхигдуулаад л тэгээд нэг баахан өөрсдөдөө л Төрийн захиргааны байгууллагууд эрх авах гэдэг, бүтэц, орон тоо ярьдаг ийм л нэг буруу жишигээр л яваад л байх юм. Тэгэхээр үүнийг бид нар бас жаахан анхаарах ёстой цаашидаа бас анхаарах нь 1 дэх асуудал.

2 дахь асуудал нь, ер нь бид нар ингээд хүүхдийн асуудлыг олон жил ярьж байгаа, үр дүн гарахгүй байгаа юм. Хэт хүүхдийн асуудлыг эцэг, эхээс нь гэр бүлээс нь салгаж ярьдаг, засаг захиргаа, орон нутгийн удирдлагаас нь салгаж ярьдаг, хүүхдийн асуудлыг хэт улс төрчид авч давхиж, улс төржүүлдэг ашигладаг. Ингээд энэ буруу бидний үйл ажиллагаанаас болоод энэ хүүхэд хамгааллын асуудал олон жил үр дүн гарахгүй байгаа юм. Нэг хэсэг хүүхдийн асуудлыг Шадар сайд хариуцах ёстой гээд л баахан авч давхисан. Сүүлд нь тэгээд л Хөдөлмөр хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд очсон. Хэт энэ хүүхдийн хамгааллын асуудлыг төвлөрүүлэх гэдэг төвөөс удирдах гэдэг, төвөөс зохицуулах гэдэг асуудал бол бид нар маш буруу олон жилийн энэ буруу замаар л явсан гэж би бол тэгж л бодоод л байдаг юм. Орон нутгийн удирдагууд хүүхэд яг тэр орон нутгийнхаа иргэдтэйгээ ажилладаг, хүүхдийнхээ асуудалд анхаардаг тэр эрх хэмжээг нь нэмэгдүүлж өгөх, гэр бүлээс нь салгаж бид нар олон жил энэ гэр бүлээс нь салгаж, эцэг эхээс нь салгаж төрийн захиргааны төв байгууллагууд хүүхдийн асуудлыг босоо тогтолцоогоор шийдэх гэж эд нар явсан энэ гажуудлаа л бид нар яг сууриар нь засах л хэрэгтэй байгаа юм л даа. Тэгээд энэ хуульд хэр засаж чадсан юм.

Уг нь одоо болдог бол би өмнө нь ч гэсэн яриад байсан юм. Гэр бүлийн асуудлыг, хүүхдийн асуудал, эцэг эхээс нь гэр бүлийн асуудлаас салгаж ярих боломжгүй юм. Гэр бүлийн хуультай уг нь зэрэгцээд хамтад нь эд нар яриад явах ёстой гэж яриад байсан. Тэгээд гэр бүлийн хууль нь бас л нэг Их Хурал руу орж ирээд тэгээд л бүдгэрээд л чимээгүй л болчихлоо л доо. Ийм бас нэг зарчмын асуудлууд байгаа юм.

2 дахь юм нь, бид нар, би бол Засгийн газрын орж ирсэн саналыг нь зөв гэж хараад байгаа юм. Засгийн газар чинь санал орж ирэхдээ энэ хүүхэд

хамгааллын ажилтны чинь асуудлыг хүн амын тоо тэр нутаг дэвсгэрийнх нь хэмжээ, засаг захиргааных нь нэгжийнх нь нөхцөл байдлаас хамааруулаад Засгийн газар тэр орон тооны хязгаар юмыг нь тогтооно гэсэн юм орж ирсэн шүү дээ. Тэгээд манай Их Хурал тэгээд л ерөөсөө Засгийн газрын орж ирсэн саналыг үгүйсгээд л, Байнгын хороо, ажлын хэсэг дээр засагтай ярихгүйгээр тэс хөндлөн юм яриад тэгээд баахан төсөв дээр ачаалал авдаг ийм л буруу жишигээр л яваад байгаа. Яг энэ жишигээр л явчхаж байгаа юм. Би бол ингээд Их Хурлаас ер нь одоо бүтэц, орон тоо ярьдаг энэ зарчим нь ерөөсөө буруу.

Тэгээд Засгийн газрын орж ирсэн хүн амынх нь тоо, нутаг дэвсгэрийн хэмжээнээс нь хамааруулаад энэ ажилтных нь тоо орон тооны хязгаарыг Засгийн газар нь тогтооно гэдэг тийм л зарчмаар явбал та бүхэнд ч хэрэгтэй. Хэн хэндээ л хэрэгтэй л дээ. Тэгэхгүй ингээд Их Хурлаас ингээд л орон тоо баталдаг, бүтэц баталдаг ийм л буруу зарчим руу бид бас манлайлаад байгаа юм. Үүнийгээ бид нар засах ёстой. Би бол..

П.Анужин: Чинзориг сайдад нэмэлт нэг минут өгье.

С.Чинзориг: Би бол Засгийн газрын өргөн барьсан тэр хувилбарыг нь зарчим нь зөв л гээд байгаа юм. Тийм учраас би энэ заавал сумд 3 мянга, хороонд 5 мянга хүүхдээ ер нь нэг хүн бий болсноор асуудлыг шийднэ гэж байхгүй шүү дээ. Бид нар хүн хүчээ зөв хуваарилаад хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээнийхээ асуудлыг оновчтой болгоод шийдвэл бас боломж ч байхгүй ч юм байхгүй бий шүү дээ. Сургуулийн нийгмийн ажилтан гээд л нэг хүн байна. Сумд чинь Тамгын газарт бас яах вэ янз янзын л ажил хийдэг байх. Нийгмийн ажилтан гээд л хүн бий. Тэгээд ийм юмнуудаа нэлээн зохицуулаад цогцоор нь хараад л явах нь зохицно. Ер нь бол Их Хурал дээр ингээд бүтэц ярьдаг, төрийн

захиргааны байгууллагуудын эрх хэмжээг нэмэгдүүлдэг, орон тоо ярьдаг энэ юмнаасаа л бид салах хэрэгтэй. Би бол Засгийн газрын тэр саналыг нь дэмжээд байгаа юм. Тэрүүгээр явбал хамгийн оновчтой л гэж.

П.Анужин: Чинзориг сайд санал хэллээ. Уг санал сая хамт явсан. Асуулт үг хамт явсан байгаа тийм асуулт үг түрүүн хамт явна гээд асуулт үг авъя гэж хэлсэн. Бас чухал хууль учраас үгийг авъя гэсэн саналыг бас олон гишүүд гаргаж байгаа учраас үг авъя. Уг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн, Дамбын Батлут гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүнээр тасалъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлье.

М.Оюунчимэг: Сая олон гишүүд асуулт асууж хариулт авч байна. Тэгээд бид нар энэ нөгөө хууль гаргаснаараа хүүхдийн хамгааллын асуудал ингээд л нэг мөр сайхан шийдэгдчихнэ гэж тийм ойлголт нийгэмд битгий өгөөрэй гэсэн асуудал хүртэл сая ярьж байна л даа. Ингээж болохгүй л дээ. Бид нийгэмд харин хүүхэд хамгааллын асуудлыг цогцоор нь стратегитай, бодлоготой шийдээд үүнийг нээрээ одоо л нэг өөр түвшинд хүргэхийн тулд энэ хуулийг гаргах гэж ингээж л нухаад л мөнгө төсвийг нь хэд дахин нэмээд л, хүний нөөцийг нь шийдье гээд л байгаа. Гэтэл одоо ингээд бараг л өнөөдрийн асуулт, хариултаас харахад нэг л нэг сэтгэл дундуур байна л даа. Яг шийдэл нь үнэхээр бас яг өмнө байгаа Хүүхэд хамгааллын тухай хууль чинь бас ч гэж тодорхой зүйлүүдтэй. Одоо бид нар төсвийг нь нэмээд өгснөөр бүх юм шийдэгдэхгүй. Энэ бол тодорхой. Төсвөөс гадна төлөвлөлт стратеги, бодлого яг цогцоороо явах энэ асуудал чухал байгаа шүү дээ.

Тийм учраас бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад яг хүүхэд хамгааллын мөнгийг жишээлбэл 14 тэрбум гэж зааж өгсөн. Одоо ингээд

харахад нийгмийн ажилтны төсөв хөрөнгө орон нутгийн аймгийн салбар нь хариуцахаар болно. Тэгэхээр дахиад энэ чинь ингээд л зааглаад явчхаж байна шүү дээ. Яам тэгвэл үгүй ээ энэ нийгмийн ажилтны асуудлыг чинь орон нутаг хариуцаж байгаа шүү дээ. Орон нутаг яагаад төсвөө өгөхгүй байгаа юм, орон нутаг эндээ яагаад ингэхгүй байгаа юм гээд л тэгнэ. Нийгмийн хамгааллын яам болохоор үгүй ээ, бид орон нутагт эрхийг нь өгсөн, хуульчилж өгсөн төсвийг нь баталсан. Яагаад орон нутаг энийгээ хийхгүй байгаа юм гээд дахиад энэ чинь хэд хэдэн эзэнтэй болоод ингээд явчхаж байна л даа. Уг нь бид нар нэг шийдсэн юм чинь ингээд нэг дорвитойхон шиг яг энэ хүүхэд хамгаалал дээр кэйс гараад ноцтой асуудал гарвал тэрийг яг л нэг л эзэн нь хариуцдаг байх. Яг буруутан нь хаана байна. Мэдээж түүн дээр ганц салбарын яам хариуцахгүй нь тодорхой, нийгмийн ажилтан хариуцахгүй нь тодорхой. Тийм учраас л ийм асуудал гарвал тэр төсвийг нь ингэсэн юм уу эсвэл тэр нийгмийн ажилтны ажиллах нөхцөлийг нь бүрдүүлж өгөөгүй яг энэ хүнд хариуцлага тооцно гээд.

Тэгээд хэрвээ энэ нь өөрөө бас хүүхдийн амь настай хүчирхийлэлтэй холбоотой ноцтой асуудал тэгээд яах вэ? Дахиад л бид нар уг нь бид хууль гаргасан юм, төсөв баталсан юм, хүний нөөцийг нэмэх гэж оролдсон юм. Тэгэхдээ уначихсан юм. 3 мянга гэсэн, 8 мянган хүний дунд болоод ингээд явж байгаа энэ тэр гээд ингээд дахиад тайлбарлаад сууж байх уу. Анхнаасаа бид нар хүүхэд хамгааллын энэ хүн амын тоо хүүхдийн яг тэр хүчирхийлэл хийх болж байгаа энэ газрууддаа маш сайн судалгаанууд хийж байгаад тэр судалгаан дээр үндэслээд тодорхой бас асуудлыг цогцоор нь оруулъя гэж ярьсан. Тэгээд хэдэн тэрбум төгрөгөөр ч билээ бас судалгаа сурталчилгааны ажлыг бид бас мэргэжлийн байгууллагаар хийлгэж байгаа гээд Булгантуяа сайд бас анх хэлж байсан. Тэгээд одоо мэдээж ингээд л орж ирээд зарим зүйлүүд нь

өөрчлөгдөж байгаа байх. Гэхдээ үүнийгээ Засгийн газар бодлогоороо авч явах, авч гарах ёстой. Тэгэхгүй бол одоо бид нар зүгээр л хууль гаргаж, нийгмийг намжаах юм уу эсвэл хүүхэд хамгааллын энэ асуудал дээр бид нар нэг том юм шийдэж байгаа юм шиг ойлголт өгөөд зогсох асуудал бидний зорилго биш шүү дээ. Энэ сая гаруй хүүхдээ энэ нэг хүчирхийллээс элдэв тохиолдлын ийм аюултай юмнуудаас хамгаалахсан. Хамгаалахын тулд бид бүх цогц бодлогоор нь, мөнгөтэй нь, төсөвтэй нь, хүний нөөцтэй нь, хууль, эрх зүйтэй нь хариуцах эзэнтэй нь, хариуцлага тооцох механизмтай нь ингэж хуулиа гаргаа л гэж ингэж ажиллаж байгаа шүү дээ.

Тэгээд саяын хариулт ажлын хэсгийн мэдээж зөндөө л ажилласан байгаа нь мэдээж ойлгомжтой. Идэрбат гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаад л байгаа. Гэхдээ анхнаасаа орж ирж байгаа яам маань Засгийн газар дээрээ ийм бас нарийн зүйлүүдээ яг ингэж тодорхой болгоод, тэгээд Их Хурал дээрээ би эд нар үүнийг үнэхээр оруулж өгөхгүй бол энэ хууль амьгүй болчих юм, хэрэгжихгүй юм гэдгээ хэлчихвэл бид нар үүнийг бас яаравчлан батлах гээд байхдаа асуудлын гол биш шүү дээ тиймээ. Тэгэхээр энэ дээр анхаармаар байна. Яг үнэнийг хэлэхэд өнөөдөр бид нар дахиад л нөгөө кэйсээ эрдэмтэн маань тайлбарлаад л. Төсөв дээр энэ 2025 оны 09 сарын 01 гэдэг энэ боломжгүй шүү дээ.

Одоо нийслэл орон нутгийн төсөвт мөнгө нь тусаагүй юмыг бид 2025 оны 01 сарын 01-нээс хэрэгжинэ гэвэл нөгөө Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль яаж эрэмдэг, зэрэмдэг болоод бөөн асуудал араасаа дагуулсан шиг юм болно шүү дээ. Тэгвэл хэрэгжих хугацааг нь ядахдаа 2026 оны 01 сарын 01 ингэж бэлдэх хугацаатай, төсөвт наад орон нутгийн төсөвт мөнгөнүүдийг нь нийслэлийн төсөвт нь суулгаж өгөөд үүнийг та хариуцна шүү, танд энэ мөнгө орж байгаа шүү. Энэ

хүүхэд хамгааллын 14 тэрбумын энэ та нарт хамаагүй шүү, энэ нь хамаатай шүү гээд. Хүний нөөцөө эндээ шийднэ шүү. Хүүхэд хамгааллын байр заавал тэнд байх ёстой шүү, энэ тэр нь тодорхой болохгүй бол энэ бас тэгээд л дундаа хаягдах юм бол болж байх шиг л харагдаад байна шүү гэдгийг хэлье.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн бас чухал санал хэллээ. Ер нь ажлын хэсгийн ахлагч бас түрүүн нэг шийдчихмээр л байгаа юм шийдчихэв үү л гэдэг үгнүүдийг хэлээд байгаа нь өөрөө маш их эргэлзээ төрүүлэхээр шийдэх гэж л оруулж ирж байгаа хууль шүү дээ. Тэгэхээр тийм зүйлүүдийг бол бас хэлсэн. Дэгийн дагуу бол асуулт санал хамт явж байхад ахин үг хэлэх ийм дэг байхгүй хэдий ч бид нар маш чухал хууль.

Дээрээс нь энэ хураагдах гэж байгаа зарчмын зөрүүтэй саналууд дээр гишүүд өөр өөр байр суурьтай байгаа учраас бас энэ байнгын хороо мэргэжлийн байнгын хороо нь үг хэлүүлэх нь бас зөв. Үүнийг бол нягталж Байнгын хороон дээрээ ярих нь зүйтэй гэж үзэж гишүүдээр үг хэлүүлж байгаа гэдгийг би бас протоколд тэмдэглүүлье.

Нэмэлт явж байгаа учраас 2 минутаар, гишүүд 2 минутад багтаагаад үг хэлье. Ажлын хэсгийнхэн 2 минутаар цагийн тохиргоог хийнэ үү гэж хүсье.

Буланы Бейсен гишүүн үг хэлье. Яг хуультай холбоотой, яг энэ яригдах зарчмын зөрүүтэй саналуудтай холбоотой үг шүү.

Б.Бейсен: Хүүхэд хамгааллын тухай хуулийг дэмжиж байгаа юм. Яах аргагүй цаг үеэ бас энэ хууль орж ирж байгаа. Гэхдээ энэ орон тоог нэмснээр ажил сайжрах уу гэдэг асуудал байна. Орон тоог нь нэмээд ажлыг нь сайжруулах уу, аль эсвэл ажиллах арга барилаа өөрчилж байгаад эрчимжүүлэх

үү гэдэг асуудал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллынхан, энэ хүүхдийн байгууллагууд анхаарахгүй бол орон нутагт бас сургуулиуд дээр, цэцэрлэгүүд дээр, захиргаанд сумууд дээр ч гэсэн сургуулиуд дээр нийгмийн ажилтан байж байгаа шүү дээ. Эд нар ажиллахгүй байгаа шүү. Үүнийг та бүгд хяналтдаа аваад сайн яахгүй бол аймгийн Засаг даргын Тамгын газарт, мөн цагдаагийн байгууллагатай хамтарсан хүүхэд хамгаалах тийм алба байдаг. Эд нар ажиллахгүй байна, үнэхээр.

Орон тоог нь нэмээд л ингээд сайжирна гэвэл бас одоо маягтай шийдвэл бас болох асуудлууд байж байгаа. Энэ дээр анхаарч ажиллахгүй бол, ер нь хяналт хийхгүй болохгүй нь. Зарим хөдөө сумууд дээр, аймгийн төвүүд дээр яадаг вэ гэхээр чинь ёс заншил зарим юутай холбоотой сургуулиуд дээр гарсан хүүхдүүд сургуулиасаа гараад завсарддаг.

Нөгөө талаар тухайн аймаг, сум аймаг ажлаа дүгнүүлэхийн тулд бас нуун дарагдуулдаг асуудлууд байж байгаа. Үүн дээр нэлээн онцгой анхаарахгүй бол ерөөсөө хүүхэд хамгааллын байгууллагууд зарим юмыг нь нуун дарагдуулдаг, ажил хийсэн оромцоглодог ийм асуудлууд байж байгаа. Энэ дээр анхаарахгүй бол болохгүй нь.

Төсвийн хуваарилалт дээр бас 2022 оны кэйсийн юугаар хуваарилж байгаа юм шиг байна. 2022 онд Баян-Өлгий аймагт 10 хэдхэн тохиолдол ирсэн. Хориод тохиолдол ч юм уу. 2023 онд далан хэдэн тохиолдол байгаа. Гэтэл 2022 оны юугаар авч үзэхэд 112 тохиолдол Өлгийд илэрсэн нь нуун дарагдуулсан асуудлууд байж байгаа байхгүй юу. Өлгий хүн амын 40 ... /минут дуусав/

П.Анужин: Дамбын Батлут гишүүн үг хэлнэ.

Д.Батлут: Өнөөдөр их чухал асуудал хэлэлцэж байна. Хүүхэд хамгаалалттай холбоотой асуудал. Орон тоо нэмснээрээ үр дүн гарчихна гэж шууд ойлгож болохгүй, бас хэлбэр байж болохгүй. Ер нь төрийн ажил сэтгэл л чухал байдаг. Бид нар бүхий л шатандаа хамтран ажиллах гэрээ контрактууд байгуулдаг. Одоо жишээлбэл сайд нар аймгийн дарга нартай гэрээ байгуулна. Аймгийн дарга нь бүх хэлтэс, агентлагтайгаа гэрээ байгуулна. Хэлтэс агентлаг нь доошоо бүх хүмүүстэйгээ. Тэр төрийн албан хаагч нар дотор чинь тодорхой чиглэл хариуцсан хүүхэд хамгааллын асуудал хариуцсан хүмүүс ч гэсэн байгаа. Бид нар өнөөдрийн байгаа бүтцээ бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй мөртлөө автоматаар шууд орон тоо нэмэгдүүлээд явна гээд явж байгаа нь хэлбэр төдий болчихоод байгаа юм. Бид нарт бүрэн дүүрэн ажиллах боломж байгаа юу, байгаа. Тэгэхээр үүнийгээ бүрэн дүүрэн ашиглах, ажиллуулах тал дээр анхаарах ёстой гэж харж байна. Ер нь төрийн ажил мэргэжил, боловсрол гэхээсээ илүүтэй сэтгэл их чухал байдаг. Хүүхдийн төлөө хүн болгон сэтгэл гаргаж ажиллах ёстой. Үүнийг л хариуцлагажуулж өгөх нь өнөөдрийн энэхүү хүүхэд хамгаалалттай холбоотой асуудалд томоохон ахиц гарах боломжийг бүрдүүлнэ л гэж харж байна. Мэдээж зөвхөн энэ хүн томилогдож тодорхой үүрэг чиглэл хүлээснээрээ хүүхэд хамгааллын ажилд ахиц гарахгүй. Орон нутгийн онцлогтой холбоотой олон чухал хөрөнгө оруулалтуудын асуудлууд ч гэсэн хүүхэд хамгаалалттай холбогдож яригдана. Автобус унаа, камержуулалтын асуудлуудаас авхуулаад гээд олон зүйлүүд дээр хөрөнгө оруулалт хийж байгаа. Тэгэхдээ түрүүн миний хэлсэнчлэн хэлбэр төдий биш илүүтэй тийм үүрэг хариуцлагыг өндөржүүлсэн байдлаар асуудалд хандах нь зүйтэй л гэдэг ийм байр суурийг илэрхийлж байна. Баярлалаа.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Миний ажил хөдөлмөрийн гараа яг энэ хорооны засаг захиргааны нэгж, анхан шатны хороон дээрээс яг нийгмийн ажилтнаас эхэлж байсан учраас би бас энэ ажлын жаргал, зовлонг бас илүү гадарлах хүн байгаа юм. Зүгээр үнэхээр өнөөдөр энэ хороод дээр нийгмийн ажилтнууд яг үнэнийг хэлэхэд байлаа гээд ямар ч эрх мэдэлгүй байгаа юм. Төсөв санхүү ямар ч эрх мэдэл байхгүй, зардал байхгүй. Дүүрэг дээр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс гээд байгаа. Түүн дээр нь очихоор бас зардал байхгүй. Яг үнэнийг хэлэхэд бид нар үйл ажиллагаа явуулах хэмнэлтийн хуулиар унааг нь машингүй байна гээд хураагаад авчихсан. Одоо тэд нар чинь тэр алс хол Улаанбаатар хотод тэр дундаа бод л доо та нар. Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг хойшоогоо ингээд гэр хороолол руу асуудал юугаар явах юм. Ямар ч унаа машин байхгүй, таксины мөнгө байхгүй тэгээд энэ уулын гэр хороолол дотор энэ халтиргаа гулгаа дээр чинь явган л явах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол энэ бүтэц орон тоонуудаа нэмэхээс гадна төсөв санхүүдээ нэмэхгүй бол үр дүн гарахгүй л гэж байгаа юм. Тэгэхгүй бол зүгээр хоосон ямар ч эрх мэдэлгүй орон тоонууд гарах гээд байна. Зүгээр л нэг орон тоо. Тэрнээс төсөв мөнгө байхгүй болчихоод унах унаа машин байхгүй, таксины мөнгө байхгүй тэгээд эд нар чинь явж чадахгүй байгаа учраас тэр судалгаа юмаа хийж чадахгүй, урьдчилан сэргийлэх ажлаа хийж чадахгүй. Эд нар чинь явж байх ёстой хүмүүс байхгүй юу. Ажил гадуур гэр хорооллоор айл өрхүүдээр явдаг. Өрөөнд оффист суудаг хүмүүс биш байнга айл өрхөөрөө явж судалгаа шинжилгээ, тандалт юмаа хийдэг, урьдчилан сэргийлэх зөвлөгөө юмаа өгдөг ийм улсууд байх ёстой. Тийм учраас энэ гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээ тэр энэ дагасан хуулиараа тэр хэмнэлтийн хуулиар хорьсон тэр заалтаа унаа машинтай байх бензин...

П.Анужин: Хүрэлбаатарын Булгантуяа сайд үг хэлнэ.

Х.Булгантуяа: Гишүүдийн хэлж байгаа бас үнэн. Мэдээж орон тоо нэмээд бол шууд асуудал шийдэгдчихгүй. Тийм учраас 2024 оны төсөв дээр хүүхэд хамгааллын зардлыг сүүлийн 3 жил нэмэгдээгүй байж байгаад нэмэгдэж орж ирсэн.

Одоо жишээлбэл түр хамгаалах байрнаас авхуулаад л зардлууд бол бүгдээрээ нэмэгдээд ороод ирчихсэн. Тэгээд бид нар үүнийгээ дагаад төрийн албан хаагчдын цалин тэтгэвэр гээд бүх зүйлээ нэмсэнтэй адилхан хүүхэд хамгааллын зардал ч гэсэндээ нэмэгдэхээс өөр аргагүй болсон. 2018 оноос авхуулаад 8 тэрбум төгрөг байсан, 2018 он, 2019 он, 2020 он гээд тиймээ. Тэгээд анх бол энэ 300 саяас эхэлж байсан. Тухайн үед манай эмэгтэй гишүүд төсөв хэлэлцэж байх яг энэ цаг үед Нийгмийн бодлогын байнгын хороо дээр ч тэр төсвийн хэлэлцүүлгийн үед ч гэсэндээ энэ хүүхэд хамгааллын зардлыг нэмэх нь зүйтэй гэж анх нэг 300 гаруй сая төгрөгийн төсөвтэй эхэлж байсан. Дараа нь 700 гаруй сая төгрөг болоод одоо ингээд 8 тэрбум төгрөг болж байгаа. Тэгэхдээ энэ хүүхэд хамгааллын зардлыг зүгээр улсын хэмжээнд нэг хүүхдэд тооцоод үзэх юм бол нэг жилийн зардал 6600 орчим төгрөг байгаа. Тэгээд нийт хүүхдүүдийн 3-ны 1 нь нийгмийн халамж хамгаалалд шаардлагатай айл өрхүүдэд, өсөж байгаа гэх юм бол тийм нэг хүүхдэд зарах зардал 20 мянга орчим төгрөг байгаа жилийн төсөв.

Дээрээс нь нэмээд ахиад бид нар яах вэ яагаад ийм хүн бас шаардлагатай байгаа юм бэ гэж үзэж байгаа вэ гэхээр үнэнийг хэлэхэд энэ хамтарсан багийн гишүүн болгон чинь бүгдээрээ өөрөө олон ажилтай, ажлын байрны тодорхойлолттой, өөр өөр байгууллагуудаас цалинждаг хүмүүс байдаг. Тэгээд бараг ажлынхаа дундуур л энэ хороон дээр байгаа хүүхдүүдийнхээ

асуудлыг олон ажлынхаа дундуур л хариуцаж хийж байгаа. Тэрбум модны тайланг өгөх, соёлын үйлчилгээнд хамрагдах, хогоо ачсан уу, үгүй юу гэдэг мэдээлэл хүргэхийн хажуугаар хүүхэд хамгааллын асуудлыг давхар хийж байгаа. Тийм ч болохоор магадгүй үр дүн бас муутай байгаад байна. гэж харж байгаа учраас хүүхдийн асуудал хариуцсан бүр тусгайлан нэг мэргэжилтэнтэй болоод тэр хүн бүх хүүхдүүдийг хорооныхоо хэмжээнд, сумынхаа хэмжээнд бүртгээд эрсдэлтэй байгаа хүүхдүүд харин байнга гэр орноор нь ордог бол...

П.Анужин: Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

Гүйцээн боловсруулах чиглэлээр зарчмын зөрүүтэй санал хураалт явуулна. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалгах шаардлагатай гэж гишүүдийн 3-ны 2 нь үзсэн бол тухайн асуудлаар дахин санал хураалгаж болох дэгийн заалтын хүрээнд зарчмын зөрүүтэй нэг санал гаргасан байгаа. Энэ саналаар дахин санал хураалт явуулах нь зүйтэй гэдэг томъёоллоор эхлээд энэ хоёроороо санал хураалгачихъя. Энэ чинь энэ 3-ыг хураалгасны дараа энэ явах юм байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах саналыг танилцуулъя.

1.Төслийн 36 дугаар зүйлийн 36.6, 36.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 36.6 дахь хэсэг болгох.

36.6 сумд 3 мянга, хороонд 5 мянга хүртэлх хүн амд хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан I байхаар тооцож ажиллуулна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Анужин, Баярсайхан, Бейсен, Жаргалмаа. Цаашид ажлын хэсэг гэнэ.

Санал хураалт явуулъя, гишүүд ээ. 36.6 дээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Уг санал 46.2 хувиар унаж байна, тийм ээ.

2.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн орон нутгийн байгууллага гэсний дараа хамтарсан баг гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69.2 хувиар уг санал санал дэмжигдлээ.

Гишүүд ээ, 3 дахь санал хураалт дээр анхаарлаа хандуулахыг хүсье. Нөгөө кэйс менежмент гэдэг чинь орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр хэлний зөвлөлөөс Булгантуяа сайд аа, санал хураалт явуулах гэж байна. Энэ дээр маш анхааралтай хандацгаагаарай. Олон гишүүдийн санал хэлээд байгаа кэйс менежмент гэсэн энэ ойлголт. Танилцуулъя уншиж.

Төслийн дэд бүлэг зүйл хэсэг заалтын кэйс менежмент гэснийг эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэж кэйс гэснийг тохиолдол гэснийг тохиолдол кэйс гэж тохиолдол бүр тус тус өөрчлөх. Хэрвээ хуучнаар нь үлдээе гэвэл бид нар энэ зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахгүй байж болно. Хэлний зөвлөлийн.

Тэгэхээр энд бас нэг ойлголтыг тодруулж хэлье. Нөгөө тохиолдлын

менежмент гэдгээр хэлний зөвлөл бас оруулж ирээгүй юм шүү. Одоо хураах гэж байгаа нь бүр маш учир дутагдалтай. Эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гээд нөгөө түрүүний тайлбараар ганцхан хэсгийг нь агуулсан тийм маш учир дутагдалтай үгээр хэлний зөвлөл оруулаад ирсэн юм. Хэрвээ энэ дээр Сарангэрэл сайдын хэлж байгаагаар тэр тохиолдлын менежмент гэсэн бол өөр хэрэг байсан. Тэгэхээр энэ чинь бүр эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гээд ороод ирсэн учраас нэг бол ажлын хэсгийн ахлагч саналаа татаж болно, тийм.

Тохиолдлын менежмент гэж ядаж орж ирээгүй байхгүй юу. Бүр илүү явцуу утгаар ороод ирсэн юм хэлний хүрээлэнгээс. Тэгэхээр ажлын хэсгийн ахлагч саналаа татаж авч болно. Чуулган дээр ахиад хэлэлцүүлэгдэх болох учраас ажлын хэсгийн ахлагч саналаа татаж болно. Тэгвэл кэйс менежментээрээ явна гэсэн үг бас. Салбар бол хэлний зөвлөлийн оруулж ирсэн саналыг дэмжихгүй байгаа. Маш явцуу утгаар орж ирсэн байна гэж үзэж байгаа тийм. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Тийм үндсэндээ ингээд энэ чинь 3 юм болчихоод байгаа юм. Бид нар тохиолдлын одоо зохицуулалт гэж анх оруулж ирсэн. Сая Их Хурлын дарга бол яг энэ орчуулга хэрэглэж байгаа нөхцөлд хэлний зөвлөлөөс юм ав гэсэн. Хэлний зөвлөлөөс ирсэн санал нь эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гээд ингээд 2 ч хэлний зөвлөл, нэг нь шинжлэх ухааны хүрээлэн байх аа. 2 газраас ийм юм ингээд хүрээд ирсэн. Тийм учраас энэ чинь шууд татаад авчих юм бол кэйс менежмент болчих гээд байгаа юм. Тэгэхээр яах вэ менежмент гэдэг үг бол одоо 44 хуульд яг тэр утгаараа орчихсон байна гээд ингээд байгаа. Тэгэхдээ яг ингэж бүр холбоо үгээрээ кэйс гээд энэ гадаад үг ороод ирчихсэн тийм хуулийн зохицуулалт бас байхгүй шүү дээ. Зүгээр салбарынхан бол үүнийг ингээд

эсэргүүцэж байна. Энэ ойлголтын зөрүү гэж мэдэхгүй. Би л лав хувьдаа нэг их тийм ойлголтын зөрүү гараад байх ямар шалтгаан байгаа юм болоо? Эрсдэлийн нөхцөлийн эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэхэд тэгвэл шууд англиар нь кэйс менежмент гэж ингэж ойлгоод явж би болохгүй ч юм байхгүй л гэж ингэж үзэх гээд байгаа юм. Тэгэхээр би бол Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу ажилласан ажлын хэсэг. Монгол Улсад энэ монгол хэлний гадаад үгт орчуулах албан ёсны хэллэгт оруулах ёстой тийм 2 л байгууллагаас нь ийм санал ирсэн учраас миний хувьд дангаараа үүнийг татаж авна гэж би арай чадахгүй ээ, энэ бас ажлын хэсэг дээрээ ярьсан.

Яах вэ, зүгээр салбарынхны хувьд эд нар бас янз янзаар энэ чинь буруу зөрүү гэж хэлж байгаа юм анхнаасаа л кэйс менежмент байх ёстой гээд л хуулийн төсөл дээр ч гэсэн тэгж орж ирж байгаа юм бол байгаа юу гэвэл байгаа тийм. Миний хувьд бол одоо ингээд Байнгын хороон дээр ажлын хэсгийн саналаар нь санал хураагаад л тэгээд чуулган дээр үүнийг олон талаас нь бас ярих байх. Тэрнээс бүхэл бүтэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэг дэд бүлэг зүгээр кэйс менежмент гэсэн энэ 2 гадаад үгээр ороод ирж би бол болохгүй юм гэж л ингэж миний хувьд хувь гишүүнийхээ хувьд ч гэсэн тэгж л үзэж байна.

П.Анужин: Ажлын хэсгийн ахлагч үг хэллээ. Бүхэл бүтэн дэд бүлэг кэйс менежмент гээд яг ийм гадаад үгээр бас явж байгаа гэдэг тайлбарыг хэлж байна. Энэ бас ийм байгаа. Анхнаасаа олон гишүүд хэлсэн. Санал хураалт явуулъя. Санал хураалтыг түрүүн уншиж танилцуулсан. Ахин уншиж танилцуулъя.

3.Төслийн дэд бүлэг зүйл хэсэг заалтын кэйс менежмент гэснийг эрсдэлт нөхцөлийн зохицуулалт гэж кэйс гэснийг тохиолдол гэж тохиолдол тус бүр тус тус өөрчлөх. Санал хураалт.

46.2 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Саяын хураалгасан саналуудтай холбогдуулж дараах саналыг явуулна. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалгах шаардлагатай гэж гишүүдийн 3-ны 2 нь үзсэн бол тухайн асуудлаар дахин санал хураалгаж болох дэгийн заалтын хүрээнд зарчмын зөрүүтэй нэг санал байна. 2 байгаа. Тухайн асуудлаар санал хураалт дахин явуулах нь зүйтэй гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ. 2 зүйл дээр санал хураалт явуулна. Энэ дээр санал хураалт явуулах нь зүйтэй гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

61.5 хувиар дэмжигдлээ. Уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах саналыг танилцуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 36 дугаар зүйлийн 36.2.4 дэх заалтын тохиолдлын зохицуулалт гэснийг мөн зүйлийн 36.2.5 дахь заалтын тохиолдол гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг түр цуцалъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлье гэсэн санал гаргаж байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлье. Санал хураалтыг цуцалъя.

М.Оюунчимэг: Өөрөө дарах юм. Энэ одоо жишээ нь гаднын нөхцөл байдал, одоо энэ Орос, Украйны дайн энэ тэрийн үед энэ хүүхдийг цахимаар дарамтлах гэдэг маш өргөн хүрээтэй агуулга болж хувирч байгаа байхгүй юу. Энд болохлоор хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цөөн мэдээллийг ашиглаж гэгчихсэн гээд орчихлоо шүү дээ. Гэтэл хүүхдийн зургийг ямар ч мэдээлэл ашиглахгүйгээр тухайн хүүхдийн зургийг

зөвшөөрөлгүй тавих, одоо сүүлийн үед бас нөгөө бүүлийдэж байгаа дунд сургуулийн хүүхдүүдийн янз бүрийн юун дээр зүгээр л зургийг нь тавиад видео юм уу шууд бичлэг хийгээд тавиад тэнд ямар ч мэдээлэл ашиглаагүй энэ тэр ийм зүйлүүд байна шүү дээ. Тэгэхээр хэрвээ энэ хуулийн заалтаар цахимаар дарамтлах гээд тухайн эцэг эх ч юм уу нийгмийн ажилтан гомдол гаргалаа гэхэд нөгөө тал нь би энэ бичлэгийг тавьсан хүмүүс нь үгүй ээ энэ чинь хувийн болон эмзэг мэдээллийг ашиглана гэсэн биш би ямар ч мэдээлэл ашиглаагүй шүү дээ. Зүгээр л зураг тавьсан шүү дээ. Зүгээр л видео бичлэг тавьсан шүү дээ ч гэдэг юм уу эсвэл зарим хүүхдүүдийн гэр бүлээрээ ч явж байхад нь хүүхдийг нь аваад л зургийг нь санаандгүйгээр тавиад л асуудал үүсгээд л. Тэрний хүүхэд ингэж байна энэ нь ийм байна ч гэдэг юм уу ингээд хүүхдийн эрхэд хүний хувийн нууцад хэт халдах энэ тэр явдал сүүлийн үед энд аягүй их гарч байна шүү дээ.

Тэгэхээр бид нар үүнийг бас энэ нэлээд ийм юу болох жоохон өргөн хүрээнд харж үзвэл яасан юм бэ, орно шүү дээ. Мэдээлэл гэхээр юу ч орж болно тийм. Хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглана гэж байгаа. Гэтэл тэр бичлэг ямар ч би мэдээлэл биш зүгээр л зураг тавьсан шүү дээ гэвэл тэр нөгөө хуулийг ямар ч 2 талаас нь тайлбарлаж болдог гэдэг шиг асуудал болохгүй тэгээд хүүхэд хохироод явчих тохиолдол гарах магадлалтай байх юм. Энэ заалт бол дэндүү тийм юу байна тийм. Тэгэхээр үүнийг жоохон өргөн хүрээнд авч үзвэл яасан юм. Ер нь энэ дээр зөвшөөрөлгүйгээр тавих ч гэдэг юм уу ер нь тэгж бодохгүй бол цахимаар дарамтлах гэдгийг энэ дэндүү нөгөө нэг өргөн хүрээнд узкий гэдэг чинь өөрөө нарийн хүрээнд ингээд дэндүү хураангуй тайлбарлачихсан байна л даа. Гэтэл өнөөдөр хүүхдийн эрх асар их зөрчигдөж байгаа шүү дээ. Одоо дөнгөж хүүхдийг хамаагүй тавих гадаа явж байхад нь ч гэдэг юм уу сая нөгөө нэг Дорноговьд болсон асуудал дээр бас тэгсэн шүү дээ.

Зургийг нь тавьснаас болоод тэр хүүхэд эрсдэлд өртсөн гэж ярьсан шүү дээ. Тэгэхээр энэ цахимаар дарамтлах гэдгийг өргөн хүрээнд тайлбарлах нь зөв болов уу гэж бодож байна.

П.Анужин: Оюунчимэг гишүүний хэлсэн санал зарчмын зөрүүтэй саналын 2 дугаар зүйл байсан. Саяын зүйл биш. Тэгэхээр хариултыг 2 дугаар зүйл дээр санал хураагдах үед, санал хураалт явуулах үед хариултыг авах нь зүйтэй гэж үзэж байна. Одоо 1 дүгээр зүйл сая би уншиж танилцуулсан. Санал хураалт. Ахиж, тэгье.

Батлут гишүүн санал хэлье.

Д.Батлут: Энэ дэмжсэн боловч төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгч, ахин санал хураалт гаргаж өгнө үү.

П.Анужин: Батлут гишүүний төхөөрөмж ажиллаагүй учраас санал саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя, гишүүд ээ. Санал хураалт. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт гишүүд ээ, саналаа өгөөрэй.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалгах шаардлагатай гэж гишүүдийн 3-ны 2 нь үзсэн бол тухайн асуудлаар дахин санал хураалгаж болох дэгийн заалтын хүрээнд зарчмын зөрүүтэй дараах саналыг танилцуулж байна.

Тухайн саналаар санал хураалт дахин явуулах нь зүйтэй гэдгээр саналын гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Эхний заалтаараа дахин санал хураалт явуулъя гэдэг томъёоллоор түүнийгээ алийг нь юм бэ? Тийм байна. Сая Батлут гишүүн зарчмын зөрүүтэй нээрээ хүчингүй

болгосон юм чинь одоо дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тийм тийм. Уучлаарай. Батлут гишүүн сая зарчмын зөрүүтэй санал гаргаад хүчингүй болгох санал хураалтад дэмжигдсэн. Одоо санал хураалт явуулъя, гишүүд ээ.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Одоо 2 дахь нь түрүүний Оюунчимэг гишүүний хэлсэн саналтай холбоотой санал хураалт явуулна. Ахин танилцуулъя. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалгах шаардлагатай гэж гишүүдийн 3-ны 2 нь үзсэн бол тухайн асуудлаар дахин санал хураалгаж болох дэгийн заалтын хүрээнд зарчмын зөрүүтэй дараах саналыг танилцуулж байна. Тухайн асуудлаар санал хураалт дахин явуулах нь зүйтэй гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүдийн 53.8 хувь нь санал хураалт явуулах нь зүйтэй гэж үзлээ.

Энэ санал гишүүд ээ сая уншиж танилцуулсан 3-ны 2 нь зөвшөөрсөн тохиолдолд дахин санал хураалт явуулна гэж байгаа. Санал 3-ны 2 хүрсэнгүй. Сандаг-Очир гишүүн та саналаа өгөөгүй байна сая. Та Сандаг-Очир гишүүн санал гаргах уу?

Ц.Сандаг-Очир: Уучлаарай, саяын санал хураалт дээр анзаараагүй байж байгаад санал өгч эсрэг гарчихлаа. Хүчингүй болгоод дахин санал хурааж өгнө үү?

П.Анүжин: Саяын санал хураалтыг хүчингүй болгох эсэхэд гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

69.2 хувиар Сандаг-Очир гишүүний гаргасан санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулъя гишүүд ээ. 3-ны 2-оор дэмжигдсэн тохиолдолд дэмжигдэнэ. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй. Санал хураалт.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

Одоо санал хураалт. Томъёоллыг би ахин уншиж танилцуулъя.

2.Төслийн 25 дугаар зүйлийн 4 дэх тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Энэ зүйлд заасан цахимаар дарамтлах гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүрт түрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл эс үйлдэхгүйг ойлгоно. Энэ дээр Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асуулт асуусан байгаа. Хариултаа аваад санал хураалт явуулъя. Тэр ажлын хэсгийн микрофон дээр очоод сууна уу та. 3 номерын микрофон дээр суугаад хариулт өгөөрэй. 3 номерын микрофоныг ажлын хэсэгт нээж өгье.

Ажлын хэсгийн гишүүн Оюунболд байна. Хүүхэд хамгааллын хуулийн төсөлтэй уялдуулаад одоо төслөөр орж ирсэн тайлбар нь Эрүүгийн хуулийн заналхийлэх гэмт хэргийн шинжтэй адилхан байсан учраас ял завиших нөхцөл үүсэж магадгүй гээд энэ тайлбарыг өөрчилж оруулж ирж байгаа.

Оюунчимэг гишүүний хэлсэн тэр санал бол одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа зөрчил Зөрчлийн тухай хуулийн 6.20 дээр хүүхдийн гэрэл зургийг зөвшөөрөлгүй ашиглах гэсэн ийм зөрчил бол одоогийн хууль дээр байгаа. Тэгэхээр бид болохоор энэ нөгөө хувийн болон эмзэг мэдээллийг ашиглаад хүүхдэд айдас түгшүүр төрүүлж байгаа тэгээд тийм шахалт үзүүлж байгаа заналхийлэх гэмт хэргээс арай нийгмийн хор аюул багатай үйлийг төсөлд ялгаж тусгаад гэмт хэргээс гэмт хэргийн шинжтэй давхиулахгүйн тулд ингээд томъёоллыг

өөрчилж ажлын дэд хэсгээс санал болгож ингэж оруулж ирж байгаа юм.

П.Анужин: Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Хүүхэд хамгааллын тухай хууль чинь харин өөрөө саяын таны хэлсэн тэр Зөрчлийн хуулийн заалттайгаа уялдах ёстой. Цахимаар дарамтлах гэдэг нь зөвхөн эмзэг мэдээллийг ашиглах биш сүүлийн үед жишээлбэл мессенжерээр, тик токоор, инстаграмаар хүүхэд рүү дарамталсан мессежүүд явуулдаг маш их болсон гэж байна шүү дээ. Танай аав ээжийг ингэдэг юм уу эсвэл ах, эгч шүү эсвэл чамайг тэгэхгүй бол би ингэнэ шүү энэ тэр гэсэн. Тэгснээ нууц хаягтай тийм зүйлүүд байгаад байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр эмзэг мэдээлэл болон цахим орчин гэхээр наадах чинь дэндүү хумигдмал байгаад байна гэдгийг би хэлээд байна л даа. Тэгвэл одоо тэр мессежээр дарамтлахыг дарамт гэж үзэхгүй нь байна шүү дээ. Би эмзэг мэдээлэл дээр тэгээгүй зөвхөн мессеж л явуулсан ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ өөрөө нөгөө та сая бид хуулийн хариуцлага хүлээлгэхийн тулд ингэж оруулж ирж байгаа юм гээд байна л даа. Тэгвэл хариуцлага хүлээлгээгүй бол үүнийгээ тодорхой болгох хэрэгтэй байна. Сүүлийн үед бол тэр тик ток энэ тэр хүүхдүүд бие бие рүүгээ тэр бүүлийдсэн дарамталсан мессеж хүртэл их явуулдаг боллоо гээд 10 жилийн багш нар арга хэмжээ авч өгөөч гээд л ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь болохгүй байхгүй юу.

П.Анужин: Санал хураалт явуулъя гишүүд ээ. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганд тус хуулийн ажлын хэсгийн ахлагч

Идэрбат Улсын Их Хурлын чуулганд танилцуулна.

13.55 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40.2-т заасныг үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан 3 хуулийн төсөл байгаа. Тус зүйл тус бүрээр нь хэлэлцэх ёстой.

1.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг эшилсэн заалт байгаа тул шинэчилсэн найруулгатай нийцүүлэн оруулж ирсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? асуулт асуух гишүүд байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Боловсролын хууль. Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах талаар тийм дагаж гарч байгаа. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн сая асуугаад байхад Идэрбат гишүүн анхааралтай байгаарай. Идэрбат гишүүн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал хэлэх юм байна. Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Хүүхэд хамгааллын хуультай дагалдах 3 хууль байгаа тэгээд

энэ хуулийн хэлэлцүүлгийг Улсын Их Хурал дээр эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатгаж явуулах ийм зарчмын саналыг гаргаж байна.

П.Анужин: Ажлын хэсгийн ахлагч Идэрбат санал гаргалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу зарчмын зөрүүтэй санал гараагүй бол анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай явуулах горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ.

61.5 хувиар уг санал дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

13.58 цаг

Хуулийн төсөлтэй нийцүүлэн боловсруулсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрс авъя байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т Идэрбат гишүүн санал гаргана. Идэрбат гишүүний микрофоныг өгье.

Ц.Идэрбат: Хүүхэд хамгааллын хуулийн эцсийн хэлэлцүүлэгтээ байнгын хорооны хурлаар сая хэлэлцсэн

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай асуудал дээр зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас эцсийн хэлэлцүүлгийг цуг хийлгэж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

П.Анужин: Идэрбат гишүүн санал гаргаж байна. Эцсийн хэлэлцүүлгийг хамтран хийж өгнө үү гэсэн санал гаргалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу зарчмын зөрүүтэй санал гараагүй бол анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай явуулах горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ. Санал хураалт.

61.5 хувиар уг төсөл дэмжигдлээ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

14.00 цаг

Дараагийн хууль. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Хуулийн төсөлтэй нийцүүлэн боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Гишүүд ээ, анхааралтай байгаарай.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зөрчлийн хуультай дагасан хууль Зөрчлийн хууль орж ирж байна. Анхны 1

дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байхгүй байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан үг хэлнэ.

М.Оюунчимэг: Түрүүн яг нөгөө 3 дээр суусан нөгөө цахим дарамтлах гэдэг дээр Зөрчлийн хууль дээр үүнийг тодорхой заагаад өгчихсөн учраас давхцахгүйгээр оруулж ирсэн гээд хэлж байна. Одоо бид нарт нэг хэд хэдэн кэйсүүд ирсэн юм. Жишээлбэл манай нэг сургуулийн 59 дүгээр сургуулийн нэг эхээс хүүхэд рүү нь аав ээжийнх нь ч юм уу эсвэл нөгөө ах эгчийнх нь зургийг нь ямар ч юугүйгээр явуулах юм уу эсвэл тухайн хүүхдийн зургийг өөр хүмүүс рүү явуулаад тэр нь ангийнхных нь дунд бөөн асуудал үүсгэсэн ч юм уу тийм зүйлүүд гараад байх юм. Ер нь энэ нөгөө цахимаар хүүхдийг дарамтлах мессежээр янз янзын юманд уруу татах үгүй бол одоо энэ өөрөө маш том хүүхдийн сэтгэл зүйн дарамт болж байна, сэтгэл зүйд нөлөөлж байна гээд яриад байгаа юм. Тэгэхээр одоо түрүүн таны тайлбарласнаар Зөрчлийн хууль дээр энэ яриад байгааг бол заагаад тусгаад өгчихсөн. Энэ эрүүгийн хариуцлага хүлээх гээд тэгсэн. Тэгэхээр үүнтэй яаж энэ Зөрчлийн хуультайгаа энэ уялдаж байгаа юм. Энэ дээр нөгөө хувийн мэдээллийг ашиглаад гэж байгаа. Тэр бол ямар ч хувийн мэдээлэл биш зүгээр хүүхэд рүү янз янзын маягаар тийм ээ зураг дүрс явуулах ч гэдэг юм уу эсвэл хүчирхийлэлд уриалах бэлгийн дарамт үзүүлэх ч гэдэг юм уу ийм зүйлүүд энэ тэр ингээд байгаа байхгүй юу тодорхой юун дээр. Тэгэхээр энэ заалтыг сая энэ Зөрчлийн хуулийн заалттай яаж уяж байгаа юм эсвэл Зөрчлийн хуулийн юунд тэр чигээр нь л оруулж байгаа юм уу? Тэгээд энэ дээр нэг хариулт өгөөч.

П.Анужин: Оюунболд 3 номерын микрофонд хариулт өгье.

Г.Оюунболд: Таны асуултад хариулъя. Оюунчимэг гишүүн, ер нь бол бид хэд хэдэн томъёоллын нэлээд сайн хуулийн Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийн бусад зөрчлүүдийг бүгдийг сайтар шалгаж нягталж үзсэн байгаа. Тэгээд төслөөрөө орж ирсэн заалт нь Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэгт заасан заналхийлэх гэмт хэрэгтэй адилхан болчихсон байсан. Тэгэхээр заналхийлэх гэмт хэргээр шийдэхгүй зөрчлөөр шийдэхэд ял шийтгүүлэх магадлалтай учраас Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжээс арай нийгмийн хор аюул багатай үйлдлүүдийг эрэмбэлж оруулъя. гээд. Тэгээд хүний хувийн мэдээлэл гэдэгт бол хүнийг тодорхойлох шууд болон шууд бус мэдээллүүд хамаарч байгаа.

Хувь хүний хүний хувийн нууцыг хамгаалах тухай хууль дээр заасан хууль зүйн ойлголт ухагдахууныг энэ зүйлд оруулж өгсөн. Таны хэлдэгчлэн тодорхой гэрэл зургаар ч юм уу эс үгүй бол ийм мэдээлэл байгаа гэдэг байдлаар айдас түгшүүр төрүүлж байгаа тохиолдолд зөрчилд тооцоод ингээд зөрчлийн шийтгэл хүлээлгэхээр оруулж ирж байгаа. Зөрчлийн субъект бол 16 наснаас эхэлж байгаа шүү дээ. Тэгээд 18 нас хүртэл бол шийтгэл оногдуулахгүй байж болохоор Зөрчлийн тухай хуулийн ерөнхий анги дээр байж байгаа. Тэгэхээр яг таны хэлээд байгаа энэ асуудал дээр нөгөө зөрчил гэж үзэхийн тулд саяын тайлбарыг өөрчлөөд тэгээд урхидаж байгаа ч юм уу, эс үгүй бол санал болгож байгаа энэ үйлдлүүдээ гэмт хэргийнхээ шинжээс маш тодорхой ялгаж өгөөд тайлбаруудаа ингэж маш тодорхой өөрчилж өгч тийм. Тэгэхээр таны ярьж байгаа энэ үйлдэл дээр шийтгэл зөрчлийн шийтгэл тооцохын тулд үүнийг оруулж ирж байгаа гэж ойлгож болно тийм.

П.Анужин: Хариулт авч дууслаа. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? байхгүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Байхгүй байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрс авъя. Санал гарсангүй.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн ахлагч Идэрбат санал хэлнэ тийм үү? За санал хэлье. Идэрбат гишүүний микрофоныг өгье.

Ц.Идэрбат: Зөрчлийн хүүхэд хамгааллын хуультай холбогдуулаад ялангуяа энэ цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлуудыг манай Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас бас нэлээн сайн ажиллаж, бас ажлын хэсэгт танилцуулсан.

Тэгээд олон зүйлүүд энэ ажлын хэсгийн уулзалтууд дээр гарч байсны нэг нь бол бид хууль дээр зааж өгөөд ард нь ямар нэгэн хариуцлагын тогтолцоо байхгүй бол энэ чинь зүгээр элсэн хууль болно гэсэн ийм л зүйлүүдийг ярьсан. Тийм учраас энэ дагалдах хуулиуд дээр энэ өөрчлөлтүүдийг бас өргөн барьж байгаа. Тэгээд зарчмын зөрүүтэй саналууд анхны хэлэлцүүлгээр гараагүй учраас чуулганы нэгдсэн хуралдаанд эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатган хэлэлцүүлж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

П.Анужин: Ажлын хэсгийн ахлагч Идэрбат хамтатган хэлэлцүүлэх талаар санал гаргалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу зарчмын зөрүүтэй санал гараагүй бол анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай явуулах горимын саналыг дэмжье гэсэн

томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

61.5 хувиар уг санал дэмжигдлээ.

Байнгын хороогоор анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэгдэх асуудал үүгээр өндөрлөсөн тул Байнгын хорооны хуралдаандаа идэвхтэй оролцсон эрхэм гишүүддээ баярлалаа.

Мөн ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ